# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТОГТООЛ

2016 оны 12 сарын 02 өдөр Дугаар 13 Мандалговь

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “а”, 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “а” дах заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 3 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн хэмжээнд 2017 оныг “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх жил” болгон зарласугай.

Хоёр.Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

Гурав. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл, дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА С.СҮХБААТАР

## Танилцуулга

Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний **Засаглалын хүрээний 25** арга хэмжээ, **эдийн засгийн хүрээний 17** арга хэмжээ, **нийгмийн бодлогын хүрээний 40** арга хэмжээ, **хүнс, хөдөө аж ахуй газар тариалан үйлдвэрлэлийн хүрээний 19** арга хэмжээ, **байгаль орчин аялал жуулчлал, уул уурхайн хүрээний 11** арга хэмжээ, **бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээний 18** арга хэмжээ, нийт 130 заалт арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний биелэлтэд 12 сарын 30-ны байдлаар үнэлгээ хийхэд 91,2 % хэрэгжилттэй байна.

Бүрэн хэрэгжсэн 93 заалт арга хэмжээ нь нийт арга хэмжээний 72 хувийг
Хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 23 заалт арга хэмжээ нь 17,4 %-ийг
Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай хэрэгжсэн 6 заалт арга хэмжээ нь 4,5 %-ийг
Үнэлэх боломжгүй 8 заалт арга хэмжээ нь нийт заалтын 6,1 хувийг тус тус эзэлсэн байна.

### ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

| № | Агуулга | Нийт арга хэмжээний тоо | Бүрэн хэрэгжсэн | Хэрэгжиж байгаа | Үүнээс | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 70 | 40 | 0 | Үнэлэх боломжгүй | |
| 1 | ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД | 25 | 17 | 8 | 7 | 1 | - | | 89,2 |
| 2 | ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД | 17 | 15 | 1 | 1 | | | 1 | 98,1 |
| 3 | НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД | 40 | 31 | 9 | 7 | 2 | | - | 91,7 |
| 4 | ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД | 19 | 15 | 4 | 2 | 2 | | | 90,4 |
| 5 | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД | 11 | 7 | 3 | 3 | | | 1 | 91 |
| 6 | БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД | 18 | 8 | 4 | 3 | 1 | | 6 | 87,5 |
| | | **130** | **93** | **29** | **23** | **6** | | **8** | **91,2** |

| | Дүн | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|

**Дүгнэлт**

Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад эхний 5 сарын байдлаар үнэлгээ хийхэд 61 хувийн биелэлттэй хэрэгжиж байсан. Үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 9 сар 11 саруудад “Сонсгол мэдээллийн” үйл ажиллагаа зохион байгуулж “Ажил эрчимжүүлэх” албан тоотоор хэлтэс агентлагуудад үүрэг чиглэл өгч ажиллалаа. Эхний хагас жил болон сүүлийн хагас жилийг харуулбал: 11 сарын 10-ны байдлаар Аймгийн ИТХ-д танилцуулахаар явцын үнэлгээ хийж хэрэгжилтийг 89,2 хувьтай биелүүлж хурлаар хэлэлцүүлсэн. 12 сарын 25-нд эцсийн үнэлгээг хийж 91,2% дүгнэгдлээ.






## Хэрэгжилт удаашралтай 40%-тай заалтууд:

| № | Арга хэмжээ | Шалгуур | Хариуцах байгууллага | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | “Залуусын дуу хоолой” чуулган, хэлэлцүүлэг зохион байгуулж, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа 18-35 насны залуучуудын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ. | -Нэгдсэн мэдээллийн сантай болсон байх<br>-Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх | НБХ<br>ГБХЗХГ | Тусгай бэлтгэсэн анкетын дагуу 15 сумдын 15379 залуучуудын судалгааг нэгтгээд байна.<br>“Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төсөлтэй уялдуулан, орон нутгийн “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан, төсөлд иргэдийн **саналыг авахаар** 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ГБХЗХГ-ын даргын 160 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байнаЗалуучуудын чуулганыг 2017 оны 12 дугаар сард зохион байгуулахаар чуулганы удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна | 40 |
| 2 | “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн гадна хашаа, тоглоомын талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | -Хашаа шинэчлэгдсэн байх<br>-Талбайг тохижуулж, тоглоомын нэр төрлийг нэмэгдүүлсэн байх | НБХ<br>ГБХЗХГ | Зуслангийн 4 бүлгийн байрны гадна 8 сандал шинээр хийж, өндөр хүчдэлийн шонгийн засварыг хамт олноо дайчлан засаж сайжрууллаа. 3 газарт төсөл боловсруулан хүргүүлээд байна. | 40 |
| 3 | Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн тэжээлийн үрийн хэрэгцээг бүрэн хангана. | Тэжээлийн ургамлын тариалалт өмнөх оноос нэмэгдсэн байх | ХОХБТХ<br>ХХААГ | Хулд суманд иргэн Т.Төмөрчулуун 0,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж байна. Аймгийн хэмжээнд нийт 30,5 га талбайд малын тэжээлийн ургамлын тариалсан хэдий ч урьд оноос тариалсан талбай 0,5 га-р нэмэгдсэн хэдий ч усны нөхцөл байдлаас шалтгаалан 30 га талбайд ургац алдаж 2017 онд нийт 3.5 тн ургац хураан авсан. | 40 |
| 4 | Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвд шинээр барилга барьж ашиглалтанд оруулна. | ✓ Шинэ барилга баригдаж, ашиглалтанд оруулсон байх | ХОХБТХ | Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилгын гүйцэтгэгчээр "ОГОСЦ" ХХК 899,443,354 төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулсан. Одоогоор 2 дугаар давхрын хучилтын ажил хийгдэж дууссан. Ажлын явц 30%-тай он дамнасан ажил хийгдэж байна. | 40 |
| 5 | Тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалах ажлыг өргөтгөх, бага оврын цех байгуулж, | Хадлан тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдсэн | ХОХБТХ<br>ХХААГ | Хулд суманд иргэн Т.Төмөрчулуун 0,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж байна. Аймгийн хэмжээнд нийт 30,5 га талбайд малын тэжээлийн ургамлын тариалан урьд оноос тариалсан талбай 0,5 га-р нэмэгдсэн хэдий ч усны нөхцөл байдлаас | 40 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тэжээлийн хангамж нэмэгдүүлж ажиллана | байх | | шалтгаалан 30 га талбайд ургац алдаж 2017 онд нийт 3.5 тн ургац хураан авсан. | |
| 6 | Аймгийн ЗДТГ-ын архивын байрыг заавар, стандартын дагуу тохижуулж тоног төхөөрөмжтэй болгоно. | Аймгийн ЗДТГ-ын архивьн өрөөний тохижилт сайжирч, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх | ТЗУХ | ЗДТГ-ын архивт 1 скайнер 1,5 сая төгрөгөөр ОНХС-аас шийдэж 9 сард авч өгсөн ба өөрийн хэлтсийн 1 каноныг архивын өрөөнд байрлуулж ашиглахаар шийдвэрлэлээ. Архивын өрөөг нүүлгэн, томсгож тоног төхөөрөмжөөр бүрэн хангахаар Аймгийн ЗДТГ-ын барилгын өрөөнүүдийн ашиглалтанд үзлэг хийж өрөөнүүдийн байр, талбай, өрөөний ашиглалтын хуваарь хийж тооцоо судалгаа гаргаж байна. Үүний дараа өрөөг нүүлгэж тохижуулах ажил хийгдэнэ. Одоо ашиглагдаж байгаа архивын өрөөний шал нь нягтруулсан шүүгээ тавихад шаардлага хангахгүй байгаа тул ажил удаашралтай явагдаж байна. | 40 |

## Гадаад хүчин зүйлээс шалтгаалсанаар үнэлэх боломжгүй байгаа 8 арга хэмжээ байна. Үүнд:

| № | Арга хэмжээ | Шалгуур | Хариуцах байгууллага | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Цэнгэлдэх хүрээлэнгийн барилга цахилгаан эрчим хүчинд холбогдсон байх | ХОХБТХ | Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлын захиалагчийн хүсэлтээр түр зогсоогоод байна. Дахин төсөв хийж тодотголоор 11 сарын 15-ны 24-р ИТХ-ын тогтоолоор 50 сая төгрөг баталсан. |
| 2 | “Дундговь хөгжил сан” байгуулах нөхцлийг бүрдүүлнэ. | Сан байгуулагдсан байх | СТСХ | Тусгай сангийн журам боловсруулахыг Сангийн яамнаас хориглосон тул журам боловсруулагдаагүй |
| 3 | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгаас санал өгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллана. | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх | ХОХБТХ | Он гарсаар ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар АМХГ-аас мэдэгдэл ирээгүй болно. |
| 4 | Аймгийн төвд 35 Мвт хүчин чадалтай дулааны станцын дулаан дамжуулах төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | ✓ 4 км дулааны шугамын ажлыг гүйцээж хийсэн байх<br>✓ Дулаан дамжуулах төвийн барилга баригдаж эхэлсэн байх | ХОХБТХ | Хөрөнгийн асуудал шийдвэрлэхээр судалгаа тайланг Эрчим хүчний яам руу материалыг хүргүүлэн ажилласан. 2017 оны 08 дугаар сарын 24-нд Бүгд Найрамдах Солонгос улсын “Экспорт Импорт” банкны төлөөлөгчид газар дээр нь ирж танилцан, 2014 боловсруулагдсан ТЭЗҮ-г БНСУ-ын төлөөлөл хангалтгүй гэж үзсэн тул “Экспорт Импорт” банкны хөрөнгөөр техник эдийн засгийн үзүүлэлтийг дахин боловсруулахаар тендерийг зарлаж 2017 оны 11-р сард компанитай 6 сард ТЭЗҮ боловсруулж дуусгах хугацаатайгаар гэрээ байгуулсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Сайнцагаан суманд 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн шинэ барилгыг барьж, ашиглалтад оруулна. | ✓ Шинэ барилга баригдаж, ашиглалтад өгсөн байх | НБХ | “Бармон” ХХК концессын гэрээ эзэмшигчээр шалгарсан ба УИХ-ын 34-р тогтоолоор гэрээ түдгэлзүүлээд байгаа. |
| 6 | Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын байрны их засварын ажил /Нэг цэгийн үйлчилгээний төв/-ыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх орчин нөхцөл бүрдсэн байх | ХОХБТХ | 2017 оны 04-р сарын 25-ны өдрийн аймгийн ИТХ-ын 15-р тогтоолоор хасагдсан. |
| 7 | Мандалговь хотын залуучуудын гудамж, төв зам дагуух ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | ✓ Аймгийн төвийн зам дагуу хашаа хайс бүхий ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байх | ХОХБТХ | Мандалговь хотын залуучуудын гудамж, төв зам дагуу мод тарих ажил аймгийн МХГ-ын замын уулзвараас -УЦУОШГ-ын замын уулзвар хүртэлх газар, Холбооны уулзвараас -Бүрд зочид буудлын урд талын замын уулзвар хүртэлх 1180 метр газарт ногоон байгууламж бий болгохоор гүйцэтгэгчийг шалгаруулах ажил аймгийн Өмчийн газар зохион байгуулсан боловч тендерт оролцохоор аж ахуйн нэгжүүд материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахаар 4 компанид санал хүргүүлсэн боловч үнийн санал ирүүлээгүй. |
| 8 | Зүүн бүсийн сум дундын эрүүл мэндийн төвийн ажилчдын байрны их засварыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Ажилчдын байрын их засвар хийгдсэн байх<br>✓ Амьдрах тав тухтай орчин бий болж эмч эмнэлэгийн ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэгдсэн байх | ХОХБТХ | Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ний 25 дугаар тогтоолоор 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад Зүүн бүсийн сум дундын эрүүл мэндийн төвийн ажилчдын орон сууц шинээр авахаар хөрөнгө нь батлагдсан. |

2017 оны төлөвлөлт, гүйцэтгэлээс харахад тухайн арга хэмжээний төсөв нь ОНХС-гийн жагсаалтад багтсан эсэх, Улсын төсвөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн тохиолдолд санал дэмжигдсэн эсэх нь тодорхой бус, мөн хугацаа шаардсан ажил арга хэмжээг эртнээс төлөвлөөгүйн улмаас тухайн арга хэмжээний хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.

Графикаар харуулбал:




**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛТСҮҮДИЙН ҮНЭЛГЭЭ**

| № | Хэлтэс | Нийт арга хэмжээний тоо | Бүрэн хэрэгжсэн | Хэрэгжиж байгаа | Үүнээс | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 70 | 40 | 0 | Үнэлэх боломжгүй | |
| 1 | ТЗУХ | 7 | 4 | 3 | 2 | 1 | | | 82,8 |
| 2 | ХОХБТХ | 48 | 33 | 8 | 6 | 2 | | 7 | 93 |
| 3 | НБХ | 45 | 33 | 12 | 9 | 3 | | | 90 |
| 4 | ХЭЗХ | 16 | 10 | 6 | 6 | | | | 88,75 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5** | **СТСХ** | 11 | 10 | | | | | 1 | 100 |
| **6** | **ХШҮДАХ** | 1 | 1 | | | | | | 100 |
| **7** | **ЦШ** | 2 | 2 | | | | | | 100 |
| **дүн** | | 130 | 93 | 29 | 23 | 6 | 0 | 8 | 91,2 |



**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭЛТЭС АГЕНТЛАГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

| Арга хэмжээний тоо | Хэлтэс нэр | Агентлаг | Нийт арга хэмжээний тоо | Бүрэн хэрэгжсэн-100% | Үүнээс | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 70 % | 40 % | 0 % | Үнэлэх боломжгүй | |
| ХОХБТХ - 48 | **ХОХБТХ** | | **10** | **6** | **1** | | | **3** | **96** |
| | | ГХБХБГ | 8 | 5 | | | | 3 | **100** |
| | | СХЗХ | 1 | 1 | | | | | **100** |
| | | ОНӨГ | - | | | | | | **-** |
| | | УЦУОШГ | - | | | | | | **-** |
| | | БОАЖГ | 10 | 5 | 4 | | | 1 | **87** |
| | | ХХААГ | 19 | 16 | 1 | 2 | | | **92,1** |
| ТЗУХ - 7 | **ТЗУХ** | | **6** | **3** | **2** | **1** | | | **80** |
| | | ОБГазар | 2 | 2 | | | | | **100** |
| | | МХГазар | +1 | 1 | | | | | **100** |
| СТСХ - 11 | **СТСХ** | | **6** | **5** | | | | **1** | **100** |
| | | ТХэлтэс | 3+2 | 5 | | | | | **100** |
| | | СХэлтэс | 2 | 2 | | | | | **100** |
| НБХ - 45 | **НБХ** | | **2** | **1** | **1** | | | | **85** |
| | | ЭМНДХ | - | | | | | | **-** |
| | | ЭМГ | 10 | 5 | 4 | 1 | | | **82** |
| | | ГБХЗХГ | 8 | 5 | 1 | 2 | | | **81,25** |
| | | ХХҮГазар | 5 | 5 | | | | | **100** |
| | | БСУГ | 16 | 13 | 3 | | | | **95** |
| | | БТСГ | 4 | 4 | | | | | **100** |
| ХЭЗХ-16 | **ХЭЗХ** | | **7** | **4** | **3** | | | | **87,1** |
| | | ШШГГ | 1 | 1 | | | | | **100** |
| | | ШША | 1 | 1 | | | | | **100** |
| | | ЦГазар | 5 | 2 | 3 | | | | **82** |
| | | УБХ | 2 | 2 | | | | | **100** |
| ХШҮДАХ-1 | **ХШҮДАХ** | | **1** | **1** | | | | | **100** |
| ЦШ-2 | **ЦШ** | | **2** | **2** | | | | | **100** |
| 130 | | | **130** | **93** | **23** | **6** | | **8** | |


Бодлогын арга хэмжээний  ажлын удааширсан байдал
8%
33%
17%
42%
Зохион байгуулалтаас-4
Хөрөнгийн асуудлаас -5
Хөрөнгө зохион байгуулалт -2
Бусад-1


Удаашралтай ба үнэлэх боломжгүй арга хэмжээг хэлтсээр харуулбал
5
4.5
4
3.5
3
2.5
2
1.5
1
0.5
0
ТЗУХ-2
ХОХБТХ-5
НБХ-4
ХЭЗХ-1
Удаашралтай




**Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж**

1. Хэлтсийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд нь өөрт хамааралтай арга хэмжээг хяналтад шуурхай авч, “Дэд хөтөлбөр, бодлого, стратеги“-ийг боловсруулан, хэлэлцүүлж батлуулах ажлыг эхний 2 улиралд багтаан шуурхай, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж хариуцан ажиллах
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг харуулахуйцаар тайлагнаж хэвших

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны
өдрийн ........тоот тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2017.12.25**

### НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД

Тогтвортой, хариуцлагатай төрийн албаны соёлыг төлөвшүүлж, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх, Шударга ёс, эрх тэгш байдлыг эрхэмлэн хууль ёсыг дээдэлсэн чадварлаг, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хууль сахиулах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зарчмыг баримтална.

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, *үр дүн* | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /сая/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1.1.*** | ***Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр*** | | | | | | |
| 1.1.1 | АЗДҮАХ-ийн -1.1.4 | Аймгийн шилдэг “Төрийн албан хаагч” шалгаруулах журам боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ. | ✓ Аймгийн шилдэг “Төрийн албан хаагч” шалгаруулах журам боловсруулан батлуулсан байх<br>✓ 2017 оны аймгийн шилдэг төрийн албан хаагчдыг шалгаруулж урамшуулсан байх | | 10,000,000 | Мөн аймгийн шилдэг “Төрийн албан хаагч” шалгаруулах журмын төслийг боловсруулан хэлэлцүүлэг явуулж Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулаад байна. 2017 онд Монголын багш нарын баяраар Аймгийн Шилдэг - 10 багшийг шалгаруулан багш тус бүрийг өргөмжлөл 1 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br><br> | 100 |
| 1.1.2 | АЗДҮАХ-ийн -1.1.11 | Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Хулд, Луус сумдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн арга хэмжээг | Тусгай удирдамжийн дагуу арга хэмжээг зохион байгуулсан байх<br>Төрийн бүх төрлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь хүргэж ажилласан байх | | | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, хөдөөгийн алслагдсан сумдын малчид, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, иргэдийн санал бодлыг сонсох, төрийн албан хаагчдад зөвлөн туслах зорилгоор аймгийн Засаг даргаар ахлуулсан түүний тамгын газрын 6-н хэлтэс, харьяа 21 хэлтэс агентлагуудын 70-78 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 3 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулна. | | | | сард Гурвансайхан, Өндөршил, 11 Хулд, Луус сумдад төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх “Иргэдээ сонсъё” төрийн үйлчилгээний нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр тус сумдад давхардсан тоогоор 500 гаруй иргэнд сургалт, зөвлөгөө өгч 5673 иргэнд үйлчилгээ үзүүлэн, 5686 гарын авлага, материал тарааж, 714 иргэнээс санал асуулга авч боломжтой зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээг авсан байна.<br><br>ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ӨДӨРЛӨГИЙГ СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛЛАА<br>2017-11-13<br>Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сумдад З даргын Тамгын газар болон хэлтэс, агентлаг төрийн үйлчилгээг явуулын байд хүргэнэ гэж тусгасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газар, түүний хар хэлтэс, агентлагууд хамтран Хулд, Луус суманд Төрийн үйлчилгээний нэг өдөрлөг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлү иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх зорилго бүхий уг өдөрлөгт 6 хэ 21 агентлагийн 76 төрийн албан хаагч оролцон давхардсан тоогоор 2000 ор иргэдэд төрийн үйлчилгээ үзүүллээ. Өдөрлөгийн үеэр Аймгийн Засаг дарга О. Эрдэнэ, хэлтэс, агентлагийн удирдлагын хамтаар иргэдтэй уулзалт хийлээ. Уулзалтанд 2 сумын 300 орчим иргэн оролцож мэдэ авахын зэрэгцээ санал хүсэлтээ илэрхийллээ. Иргэд өвөлжилт, отор нүүдэл, газар өмчлөл, бэлчээрийн усан хангамж нэмэгдү ОНХСанг нэмэгдүүлэх, Мал тооллогыг бодитой явуулах, ХАА-н чиглэлээр авдаг тайлан мэдээг статистикын тайлан мэдэ уялдуулах зэрэг орон нутагт тулгамдаж буй асуудлаар санал хүсэлтээ илэрхийлсэн юм. Санал хүсэлтэд холбогдох хариуг хэл агентлагийн удирдлагууд өглөө. | |
| 1.1.3 | АЗДҮАХ-ийн -1.1.16 | Эрүүл мэнд, боловсрол, соёл, урлагийн албан хаагчдыг дотоодод болон гадаад оронд туршлага судлуулах, сургалт арга хэмжээнд хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ. | Соёл урлаг, боловсролын ажилтнуудыг урлаг соёлын үйл ажиллагаанд оролцуулсан байх<br><br>Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээнд хамруулсан байх | | | ОХУ-ын Улаан-Үд, БНСУ-ын Гуянг хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн, Бугат, Хөх хотууд, Япон улсын Шикокү муж, Эхиме мужуудад аймгийн засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал, олон улсын хурал, чуулга уулзалтанд оролцлоо. Төрийн байгууллагын албан хаагчид, хувийн хэвшлийн төлөөлөл нийт 110 хүн дээрх гадаад арга хэмжээнүүдэд оролцлоо. Мөн аймгийн ТХДЖТ-ын уран бүтээлчид БНСУ-ын Чүнбүк язгуур урлагийн нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу БНСУ-аас 40, Монгол улсаас 20 уран бүтээлчид солилцон ажиллаж байна. Франц улсад эрүүл мэндийн чиглэлээр 2 их эмч, БНХАУ-д удирдлагын чиглэлээр 3 хүн, , ХАА-н чиглэлээр 2 мэргэжилтэн, Сингапур улсад эрүүл мэндийн чиглэлээр 1 мэргэжилтэн, БНСУ-д гамшгаас хамгаалах чиглэлээр 1 аврагч нийт 9-н төрлийн сургалтанд , 9-н төрийн албан хаагчийг гадаадын сургалтанд хамруулаад байна.<br>2017 онд дотоодын 71 удаагийн сургалтанд нийт давхардсан тоогоор 1160 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулж чадавхжуулсан байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.4 | АЗДҮАХ-ийн -1.1.15 | ОХУ, БНХАУ, БНСУ, Чех улстай тогтоосон гадаад харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын чиглэлээр гүнзгийрүүлнэ. | Гадаад харилцааны хамтын ажиллагаа өргөжсөн байх Бизнес, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулсан байх | | 146 сая – жайка, 18 сая-хятадын консул | 2017 онд Европын орнууд, ОХУ-ын Улаан-Үд БНСУ-ын Гуянг хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн, Бугат , Хөх хотууд, Япон улсын Шикокү , Эхиме мужуудад аймгийн Засаг дарга тэргүүтэй төр, бизнес, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөл 110 хүн ажлын айлчлал, олон улсын хурал, сургалт, аялал, ажил хэргийн уулзалтуудад оролцсон байна. Шотланд улсын Ливингстон хотын Өргөмжит консул, Япон улсын Шикокү мужийн Канэширо компани, БНХАУ-ын Эрээн, Бугат хотын дарга нарт хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулж, саналыг хүргүүллээ. Мөн аймгийн ТХДЖТ-ын уран бүтээлчид БНХАУ-ын Эрээн, Бугат, Хөх хотуудтай хамтран ажиллах, санал солилцон БНСУ-ын Чүнбүк язгуур урлагийн нийгэмлэгтэй байгуулсан гэрээний дагуу уран бүтээлчид солилцон айлчлан тоглолт хийж хамтран ажиллаж байна.<br>БНСУ-ын Гуянг хоттой хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил, Японы Өвсний үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр 146 сая төгрөгний их засварын ажил, БНХАУ-ын Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газрын тусламж дэмжлэгээр 18 сая төгрөгийн ногоон байгууламжийн ажлууд тус тус хийгдэхээр болоод байна. | 100 |
| 1.1.5 | АЗДҮАХ-ийн -1.2.5 | Аймгийн ЗДТГ-ын архивын байрыг заавар, стандартын дагуу тохижуулж тоног төхөөрөмжтэй болгоно. | Аймгийн ЗДТГ-ын архивьн өрөөний тохижилт сайжирч, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх | | 1,5 ОНХС | Одоо ашиглагдаж байгаа архивын өрөөний шал нягтруулсан шүүгээ тавих шаардлага хангахгүй байгаа тул Аймгийн ЗДТГ-ын барилгын өрөөнүүдийн ашиглалтанд үзлэг хийж ЗДТГ-ын архивын өрөөг томсгож тохижуулахаар төлөвлөн ажлын хэсэг байгуулан өрөөнүүдийн байр, талбай, өрөөний ашиглалтын хуваарь хийж тооцоо судалгаа гаргаж байна. Үүний дараа өрөөг нүүлгэж тохижуулах ажил хийгдэнэ. ЗДТГ-ын архивын өрөөнд 10-р сард 1 скайнер 1,5 сая төгрөгөөр шийдэж өгсөн ба өөрийн хэлтсийн 1 каноныг архивын өрөөнд байрлуулахаар шийдвэрлэлээ. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1.2.*** | ***Хууль ёсыг бэхжүүлэх чиглэлээр*** | | | | | | |
| 1.2.1 | АЗДҮАХ-ийн -1.2.1 | Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх арга зүй, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, захиргааны байгууллагуудын эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулж, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт хангагдсан байх Хуульд нийцсэн зөрчилгүй шийдвэр гаргаж байх | | 684,0 | Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран “Захиргааны ерөнхий хууль”, “Захиргааны хэм хэмжээний акт” сэдвээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, сумдын Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агетнлагийн дарга, нийт 100 гаруй төрийн албан хаагч хамрагдсан ба сургалтанд зориулж 684,0 мянган төгрөг зарцуулаад байна. “Аймгийн Засаг даргын захирамжийн төслийг хянах, баталгаажуулах, сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актыг хянах журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад иргэд болон албан хаагч нарын оролцоог нэмэгдүүлэн ажилласан. Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нар, Засаг даргын дэргэдэх харьяа агнетлагийн дарга нараас 2017 онд батлан гаргасан нийт 1323 эрх зүйн актыг хянаж, заавар зөвлөмж өгч ажиллаж байна. Өндөршил, Гурвансайхан сум, Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн албан хаагчдад нийт 108 төрийн албан хаагчид “Захиргааны ерөнхий хууль”-аар сургалт зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжоор гарын авлага, материал тарааж ажиллалаа. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2 | АЗДҮАХ-ийн -1.2.3 | Сумдын “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, удирдлага, арга зүйгээр хангаж, эрх зүйн сургалт, сурталчилгааг чанар, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан тоо, хамрагдсан иргэд, байгууллагын тоо өссөн байх | Эхний хагас жилд 11 удаагийн сургалтаар 600 иргэд, албан хаагчдыг хамруулсан | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 687300 мян.төг, аймгийн ГХУСАЗСЗ-аас 100 мян.төг зарцуулсан | Тус оны “Эрх зүйн хөтөч” багийн ахлагч буюу сумын ЗДТГ-ын дарга нарыг чадавхжуулах сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 23; 24-ний өдрүүдэд Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран 14 сэдвээр чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа. “Иргэний эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сумын Засаг даргын тамгын газрын албан тушаалтан, албан хаагчдаас 2017 онд судлах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах хууль тогтоомжийн жагсаалтыг улирал бүр 6 хууль тогтоомжоор зохион байгуулахаар боловсруулан хүргүүлж, сум, багийн Засаг дарга, сумын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, хэлтэс, агентлагийн   дарга нар нийт 199 албан хаагчдад эрх зүйн сургалтыг 11 удаа 600 гаруй албан хаагч, иргэдэд, сурталчилгааг 6 удаа тус тус зохион байгуулж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн байдлыг бататган 2 байгууллагад хууль тогтоомжоор асуулт хариулт бүхий уралдаан  тэмцээнийг зохион байгууллаа. Иргэдэд хууль тогтоомж сурталчлах “Хуулийн цаг” радио нэвтрүүлгийн байнгын удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, хууль хяналтын байгууллагуудыг сар бүрийн 01-30-ны өдрүүдэд сард 1 удаа Аюулаас сэрэмжлүүлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цогцолбор FM107.5-аар өдөр бүр иргэд, олон нийт, малчдад хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. Эдгээр арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрх зүйн сургалт, сурталчилгаа 4-өөр, иргэд, албан хаагчдын оролцоо 100-аар тус тус нэмэгдэж хамрагдсан байна. | |
| 1.2.3 | АЗДҮАХ-ийн -1.2.2 | Иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд Иргэний нийгмийн байгууллагууд болон хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Хууль хяналтын байгууллагаас иргэд, олон нийтэд хүргэх хууль зүйн туслалцаа тогтмолжсон байх | Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэдийг үнэ төлбөргүй өмгөөлсөн | Улсын төсвөөс 2770,0 мян. төг | Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийг аймгийн Засаг даргын Тамгын газраас ажлын өрөөгөөр хангаж, тус оны эхний хагас жилд хууль зүйн зөвлөгөөг 188, өмгөөллийн үйлчилгээг 29, нийт 217 иргэнд хууль зүйн болон өмгөөллийн туслалцаа үзүүллээ. Үүнээс шүүхээр 21 холбогдогчтой 20 хэрэг, шүүхийн өмнөх шатанд 7 холбогдогчтой 4 хэргийг тус тус шийдвэрлүүлсэн. Хууль зүйн туслалцааны өмгөөлөгч тус оны эхний хагас жилд Гурвансайхан, Өндөршил сумдад   “Иргэдээ сонсъё” арга хэмжээнд оролцон иргэдтэй уулзаж, 12 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн нь төлбөрийн чадваргүй иргэдийг үнэ төлбөргүй өмгөөлсөн үр дүнтэй арга хэмжээ болсон. | 100 |
| 1.2.4 | АЗДҮАХ-ийн 1.2.4 | Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтийн оролцоотой төлөвлөн, Иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн | Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг хангах | Иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдсэн | ОНХС -3 сая | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг 2017-2019 онуудад хэрэгжүүлэх төлөвлөгөөг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн саналыг нэгтгэн боловсруулж, аймгийн Засаг даргаар 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдөр батлуулан Авлигатай тэмцэх газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 28 хэлтэс, агентлаг, алба, 15 суманд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэн, www.dundgovi.gov.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, 430 иргэд, албан хаагчдад сурталчлан таниулж | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгүүлж, үр дүнг тооцно. | | | | хэрэгжилтийг зохион байгуулан заавар зөвлөгөөгөөр ханган хамтран ажилласны үр дүнд төрийн албыг ил тод, нээлттэй, хүртээмжтэйгээр зохион байгуулан ажиллуулан хэвшүүлээд байна. Уг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн зарим ажил үйлчилгээг Иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр“Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” төслийг боловсруулж Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 3,0 сая.төгрөгний өртөг бүхий төслийг батлуулан хэрэгжүүлэх ТББ-ыг сонгон шалгаруулах ажил явагдаж байна. | |
| 1.2.5 | АЗДҮАХ-ийн -1.2.4 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг бүрэн хянуулж, ашиг сонирхлын зөрчилгүй томилгоог бүх шатанд хэвшүүлнэ. | Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах нөхцөл бүрдэх. | Ашиг сонирхлын зөрчилгүй томилгоо хийгдэнэ | - | Тус онд Нийтийн албанд нэр дэвшсэн 18 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, зөрчилтэй дүгнэлттэй 1 этгээдийг томилохоос татгалзаж, томилогдсон 15 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, ХАСХОМ программын ЭБАТ цэсний ХАСХОМ хүлээн авсан бүртгэлд бүртгэж, баталгааны маягтаар баталгаажуулан, ашиг сонирхлын зөрчилгүй томилгооны шийдвэрүүдийг батлан гаргуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.6 | АЗДҮАХ-ийн -1.2.6 | “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн архивын баримтын 40-өөс доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Төрийн архивын баримтын 40-өөс доошгүй хувь цахим хэлбэрт шилжсэн байх | | | Үндэсний хөтөлбөрийн 4 дэх үе шатны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 8 сарын байдлаар 27 хөмрөг  үүсгэгч байгууллагын 404 ХН буюу 30821 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж, 26 хөмрөгийн 407 ХН-ийн 32052 хуудас баримтанд холболт буюу скайнердаж засвар хийлээ. | 100 |
| 1.2.7 | АЗДҮАХ-ийн -1.2.5 | Төрийн байгууллага, албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, архив, албан хэрэг, хөтлөлтийн ажилтнуудыг мэргэшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | Төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт сайжирсан байх | | | Аймгийн Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, УЦУОШАлбаны ажилтан албан хаагчид болон сумдын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, дүн бүртгэгч, татварын байцаагч, БСГазар болон харъяа байгууллагууд ын дарга, эрхлэгч, ажилтнуудад архив, албан хэрэг хөтлөлтийн  талаар сургалт явууллаа. Мөн сумдын багийн Засаг дарга нарт албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 180 гаруй хүн оролцов. МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвд суралцуулах тухай захиалгыг сум, байгууллагуудаас авч Архивын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ерөнхий газарт хүргүүлсний дагуу 2017онд анхан шатны сургалтанд **15,** давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд 17 архив, бичиг хэргийн эрхлэгч нарыг хамруулан сургалаа.<br>Хууль зүй Дотоод хэргийн Сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2005 оны 15/41/25 тоот тушаалаар батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгуулах тухай" зааврыг хэрэгжүүлэх зорилгоор 2017 он гарсаар 12 сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд зөвлөх зэрэг олгуулахаар материалыг АЕГ-т хүргүүлж, 2 сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн тэргүүлэх зэрэг, 4 сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд ахлах зэрэг тус тус олгууллаа. Хуулийн зөвлөхтэй хамтран давхардсан тоогоор 25 сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, байгууллагын дарга эрхлэгчдээс гаргаж буй тушаал шийдвэрт баримт бичгийн стандартын талаар зөвлөмж бичиж хүргүүллээ. | |
| 1.2.8 | АЗДҮАХ-ийн -1.2.8 | Бүртгэлийн байгууллагыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, аймгийн хэмжээнд бүртгэгдсэн 10000-аас доошгүй эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг цахимжуулж, үйлчилгээний шуурхай, хүртээмжтэй | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд богино хугацаанд шуурхай авах нөхцөл бүрдэж, ТҮЦ машинаас эд хөрөнгийн лавлагааг олгож хэвшүүлсэн байх | | Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 10,0 сая төг шийдвэр-лэсэн | Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудал оруулж 2 сканнер, 1 зөөврийн компьютер, 1 суурин компьютерийг 10.0 сая төгрөгөөр авахаар шийдвэрлүүлж, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан техникийн тодорхойлолтын дагуу дээрх тоног төхөөрөмжийг "МТС" ХХК-иас нийлүүлсэн. Бэлтгэл ажлын хүрээнд Хэлтсийн даргын 08 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 9942 ширхэг хувийн хэргийг 4-5 дугаар сард багтааж хувийн хэрэг нэг бүрийг  | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлыг хангана. | | | | нүд үзэн тооллогод оруулж нотлох баримтуудыг тусгаарлан ангилан ялгаж, 540000 хуудсыг дугаарлах ажлыг хийж дуусгаж бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Шинээр олгогдсон тоног төхөөрөмжид хувийн хэрэг нэг бүрийг скайнердан цахим сан үүсгэж оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн мэдээллийн санд холбосон. Иргэд ТҮЦ машинаас эд хөрөнгийн лавлагааг авч эхлээд байна. | |
| 1.2.9 | АЗДҮАХ-ийн -1.2.10 | Сайнцагаан сумын төвийн багуудын иргэдийн оршин суух хаягийн мэдээллийг зөрчилгүй болгох ажлыг зохион байгуулна. | Хаягийн давхардал, зөрчилгүй болсон байх | | | Сайнцагаан сумын ЗД-ын батлагдсан удирдамжаар сарын аян зарлагдаж багийн иргэдийн мэдээллийг ХАӨМСантай нэг бүрчлэн тулгаж хаягийн давхардал, хаягийн зөрчлийг илрүүлэн 21 иргэний мэдээллийг засварлан зөрчилгүй болгосон. ОӨУБЕГазраас 4 дүгээр сард хаягийн давхардал, хаягийн зөрчилгүй аймаг гэж үзэж холбогдох судалгааг ирүүлж тодруулга мэдээллийг авсан. | 100 |
| 1.2.10 | | Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа уурын зуухнуудын манометр, сумдын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдэд ашиглагдаж байгаа автоклавны манометрүүдийг шалгаж баталгаажуулна. | Манометр, автоклавны манометрүүдийг шалгаж баталгаажуулсан байх | | | Уурын зуухнуудын манометр, сумдын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдэд ашиглагдаж байгаа автоклавны манометрийг шалгах тоног төхөөрөмжийг хэмжих хэрэгслийн тусгай зөвшөөрөл бүхий “Эталон” ХХКомпани нийлүүлж Стандарт Хэмжил зүйн хэлтсийн өмч хөрөнгөд бүртгэж авсан.<br>Тоног төхөөрөмжтэй болсноор “Тэвшийн говь”, “Ган-Илч”, “Дундговь-Ус” ОНӨҮГ, Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төв болон сумдын уурын зууханд ашиглагдаж буй 120 ш манометр шалгаж баталгаажуулла. | 100 |
| ***1.3.*** | ***Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах чиглэлээр*** | | | | | | |
| 1.3.1 | АЗДҮАХ-ийн -1.3.1 | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тусгайлан төлөвлөж, | Гэмт хэрэг, зөрчил буурсан байх | | | Аймгийн ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчилж, Зөвлөлийн 2017 оны төлөвлөгөө хэлэлцүүлэн батлуулсан. Зөвлөл шинэчлэгдсэнтэй холбогдуулан сум, байгууллага хариуцсан гишүүдийн хуваарийг шинэчилж, сумдын ГХУСЗ, Засаг дарга нарт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааг өргөжүүлж үр дүнд хүрнэ. | | | | хүргүүлээд байна.<br>2016 оны аймгийн хэмжээний гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл, анхаарах асуудлуудын талаарх Цагдаагийн газрын мэдээллийг хэлтэс, агентлагийн удирдлагуудад 1 удаа, аймгийн ГХУСАЗЗ-д 1 удаа тус тус танилцуулж зөвлөмж мэдээллээр хангаж, гарсан санал, дүгнэлтийг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.<br>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх, аливаа хүчирхийлэл, танхайрал, хулгай болон зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо, идэвх санаачлагыг нэмэгдүүлэх үүднээс "ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛГҮЙ-АЮУЛГҮЙ АМАР ТАЙВАН ОРЧИН" уриалга бүхий аяны цом, дэвтрийг суманд 14 хоног, байгууллагад 7 хоног аялуулж байна. Тус аяныг 2017 оны 12 дугар сарын 25-нд дүгнэж, Гэмт хэрэг зөрчилгүй сум, байгууллага баг, хамт олныг шалгаруулна.<br>"Иргэдээ сонсъё" аймгийн ЗДТГ-ын төрийн үйлчилгээний нэгдсэн өдөрлөгийн үеэр Өндөршил, Гурвансайхан сумын ГХУССЗ-ийн гишүүдэд арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгч, цаашид анхаарах асуудлын талаар заавар өгч ажиллалаа. | 70 |
| 1.3.2 | АЗДҮАХ-ийн -6.2.16 | Аймгийн төвийн замын зарим газруудад гэрлэн дохио байрлуулж, замын тэмдэг, тэмдэглэгээ, албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн зогсоолыг нэмэгдүүлэх, байгууллага, аж ахуйн нэгжийн | Замын тэмдэг, тэмдэглэгээ, зогсоол нэмэгдсэн байх Байгууллага, аж ахуйн нэгжийн гадна дотор орчныг хянах камерын тоо нэмэгдэж, ашиглалт сайжирсан байх | | Замын сан 54,0 сая Орон нутгийн хөрөнгөөр 48,0 сая | 2017 оны Замын сангийн хөрөнгөөр 40 сая төгрөгөөр замын хэвтээ тэмдэглэл, 12 сая төгрөгөөр нөхөөс, 2 сая төгрөгөөр 2ш хурд сааруулагчийн ажлыг "Их логийн говь" ХХК гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.<br>Орон нутгийн хөрөнгөөр аймгийн төвийн ундны усны гүний худгуудад 16ш хяналтын камерын систем суурилуулах ажлыг "Рийлсофт" ХХК-тай 38,073,000 төгрөгөөр гэрээ байгуулан хүлээлгэн өглөө. Мөн улсын төсвийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр Музейн барилгын 6ш хяналтын камер байрлуулан хүлээлгэн өгч байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хариуцлага, сонор сэрэмжийг дээшлүүлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж зохион байгуулна. | | | | | |
| 1.3.3 | АЗДҮАХ-ийн -1.3.5 | Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулж, хүүхдийг гэмт хэрэг зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулна. | Хүүхдийн эрхийн эрх зүйн хороо байгуулагдаж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх<br>Хүүхэд холбогдсон гэмт хэрэг, зөрчил буурсан байх | | - | Аймгийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г Засаг даргын А/87 дугаар захирамжаар байгуулан, хорооны гишүүдэд шийдвэрийг хүргүүлсэн. ГБХЗХГ-тай хамтран “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” аяныг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд 2017.10.04-ний байдлаар хүүхэд холбогдсон гэмт хэрэг гараагүй байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 100% буурсан. | 100 |
| 1.3.4 | АЗДҮАХ-ийн -1.3.4 | Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж “Архигүй Дундговь” | Архины хамааралтай иргэдийн тоо багасч, архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагаа идэвхжсэн байх<br>Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байх | | | “Архигүй Дундговь” аймгийн хөтөлбөрийг шинэчлэн батлах болсонтой холбогдуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулж байна. Энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл боловсруулж байна.<br><br>Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эхний 10 сарын байдлаар өнгөрсөн мөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 22 буюу 39,3%-иар буураад байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | |
| 1.3.5 | АЗДҮАХ-ийн -1.3.7 | Мал сүргийг хамгаалах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд малчид, иргэдийн идэвх санаачилгыг өрнүүлж, малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сурталчилгаа мэдээллээр хангана. | Малчдын санаачлагаар бүлэг, нөхөрлөл нэмэгдэж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх Мал хулгайлах гэмт хэрэг буурсан байх | | | Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар багийн хурал болон иргэдийн нийтийн хурал дээр яриа таниулга хийж малчдыг гарын авлага, материалаар хангаж ажиллаж байна. 2017 он гарсаар “Шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагч, НХЖХТ-ийн алба хаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох гарч болзошгүй эмзэг цэгүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Мал, мах түүний арьс шир худалдан борлуулдаг ААНБайгууллага болон хувиараа бизнес эрхлэгч нарыг оролцуулан “Хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж Зөвлөгөөнөөс дараах уриалгыг гаргасан.<br>Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, уг төрлийн гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор аймгийн төврүү хулгайн мал, мах тээвэрлэн ирж болзошгүй зам маршрутанд хөдөлгөөнт болон явган эргүүлийг тогтмол ажиллуулж Сайнцагаан сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хүнсний зах, мах, махан бүтээгдэхүүн худалдаалдаг цэг, мал, мах, түүхий эдийн наймаа эрхэлдэг иргэд /ченж/ нарт хяналт тавин ажиллаж эргүүл хяналт шалгалтын явцад 23 тээврийн хэрэгсэл шалгаж, мал, мах гарал үүслийн гэрчилгээгүй, мал мах тээвэрлэсэн 3 тээврийн хэрэгслийн жолоочийн зөрчлийг арилгуулж ажилласан. УБ-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай засмал зам дагуу 24 цагийн замын постыг ажиллуулан мал мах тээвэрлэж яваа автомашин тээврийн хэрэгслүүдийг шалган, хяналт тавьж, гарал үүслийн гэрчилгээг тогтмол шалган ажиллаж байна. | 70 |
| 1.3.6 | | Шийдвэр | Орон нутгаас зохих | | | 2017 оны эхний 04 сарын байдлаар Шүүхийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хэвийн явуулах, шийдвэрлэх, олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлэн шүүхийн шийдвэрийн биелэлтийг ахиулна. | дэмжлэг үзүүлсэн байх Шүүхийн шийдвэрийн бодит биелэлт өссөн байх | | - | шийдвэрээр хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдсөн 458 иргэн, хуулийн этгээдийн эрхийг сэргээх, хамгаалах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зохион байгуулсан. Үүнээс: Төлбөрийн 269 иргэн, хуулийн этгээдэд холбогдох гүйцэтгэх баримт бичгийн 1,1 тэр бум төгрөгийг барагдуулахаас 75 иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх баримт бичгийн 132,6 сая төгрөгийг биелүүлэн ажилласан. Төлбөр барагдуулах шүүхийн шийдвэрийн биелэлт 28 хувьтай. Өнгөрсөн 2016 оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх хуудас -2,0 хувиар буурч, мөнгөн дүн 1,1 хувиар өссөн, биелүүлсэн шүүхийн шийдвэрийн тоогоор 18-аар өссөн үзүүлэлттэй байна.<br>ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх газраас шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шатахууны зарцуулалт багатай тээврийн хэрэгсэл хуваарилсныг 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч аймгийн төвд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ашиглаж байна. | 100 |
| 1.3.7 | | Шүүхийн шинжилгээний албаны болон алба хаагчдын орон байрны асуудлыг шийдвэрлэнэ. | Шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчин нөхцөл сайжирсан байх | | - | Тус албыг аймгийн ЗДТГ-аас түрээсийн байраар ханган үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ 1 албан хаагчийг албаны орон сууцаар хангасан. | 100 |
| 3.3.1 | **3.1.1** Айгийн тэргүүлэх спортын төрлийг тодорхойлон аймгийн өсвөр үеийн шигшээ багийг байгуулж, дэмжлэг үзүүлнэ. | Биеийн тамир спортын өсвөр үеийн шигшээ багуудыг журмын дагуу байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслээр бүрэн хангахад дэмжлэг үзүүлнэ. | ✓ Шигшээ багуудыг байгуулсан байх<br>✓ Тоног төхөөрөмж, материал хэрэгслээр бүрэн хангагдсан байх<br>✓ Тамирчдын тоо урьд оноос өссөн байх | | 30.0 Орон нутгийн төсөв | Аймгийн өсвөрийн шигшээ багийг волейбол, хөнгөн атлетик, жудо бөх, ширээний теннис, үндэсний бөх, сагсан бөмбөг, хөл бөмбөг, шатар гэсэн 8 төрлөөр байгуулан, хичээллүүлж шинээр таеквондогийн төрлийг нэмэгдүүлэн хичээлүүлж байна . Хичээллэгсэдийн тоо өмнөх оныхоос 15 хувиар өссөн үзүүлэлтэй харагдаж байна. "Өсвөрийн шигшээ багийг тоглолтын хувцсаар хангах" төсөл боловсруулан, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, орон нутгийн хөрөнгийн 6.2 сая төгрөгөөр санхүүжүүлэн шийдвэрлэсэн. Уг ажлыг "Монлайн" спортын хувцсны үйлдвэрийн аймаг дахь салбар "Хандаа тайлор" ХХК гэрээний хугацаандаа гүйцэтгэж, тоглолтын хувцсыг Биеийн тамир, спортын газарт хүлээлгэн өгснөөр өсвөр үеийн шигшээ багийн тамирчдыг тоглолтын хувцсаар хангасан. | 100 |
| 3.3.2 | | Сагсан бөмбөгийн "Сурагчдын Лиг" тэмцээнийг улирал болгон зохион байгуулж, сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлнэ. | Сагсан бөмбөгийн спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байх | | | Сурагчдын лиг сагсан бөмбөгийн тэмцээнд 2 насны ангилалын 20 багийн 200 тамирчид оролцохоор мэдүүлгээ ирүүлээд байна. Үүнээс үзэхэд тэмцээнд оролцогчдын тоо өмнөх оноос 10 хувиар өсөхөөр харагдаж байна. Тэмцээн 2017 оны 11 сарын 13-аас 12 сарын 10–ны хооронд зохион байгуулагдаж байна. | 100 |
| 3.3.3 | **3.1.2** Дундговь | "Бага олимп" тэмцээнийг зохион | 6-аас доошгүй төрлөөр зохион | | 26.404,400 Орон | Дундговь "Бага Олимп-2017"-г зохион байгуулах комиссыг аймгийн Засаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн “Бага олимп” наадмыг зохион байгуулж, ард иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлнэ. | байгуулж, иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх идэвхи сонирхлыг нэмэгдүүлнэ. | байгуулсан байх Спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байх | | нутгийн төсөв | даргын 2017 оны А/342 дугаар захирамжаар байгуулсан. "Бага Олимп-2017"-г тусгай удирдамжийн дагуу волейбол, сагсан бөмбөг, үндэсний бөх, дартс, ширээний теннис, шатар, даам зэрэг спортын 7 төрлөөр зохион байгуулж, нийт 15 сумын 17 багийн 1060 гаруй тамирчид оролцож, хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Үүнээс үзэхэд спортоор хичээллэж буй насанд хүрэгчдийн тоо өмнөх онуудтай харьцуулахад 45 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Багийн нийлбэр дүнгээр Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын багууд тэргүүллээ. Энэхүү наадмыг насанд хүрэгчдийн дунд анх удаагаа зохион байгуулж байгаа бөгөөд нийт 26 сая төгрөгийн төсөв санхүүжилт зарцуулсан. | |
| 3.3.4 | | “Үндэсний сурын харваа” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | Хөтөлбөр боловсруулж, батлуулсан байх | | | Аймгийн Үндэсний сурын холбоо 2017 оны 02 сард бүх гишүүдийн хурлаа хийж, удирдах зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан үйл ажиллагаа явагдаж тэмцээн уралдаан зохион байгуулж байна. Монголын үндэсний сурын холбооноос 2017 оны 05 сарын 21 өдөр батламж авсан. “Үндэсний сурын харваа” хөтөлбөрийг боловсруулж Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлагдлаа. | 100 |
| ***3.4. Соёл урлагын чиглэлээр*** | | | | | | | |
| 3.4.1 | Соёл, урлагийг 2017-2020 онд хөгжүүлэх аймгийн бодлого боловсруулан | Соёл, урлагийг 2017-2020 онд хөгжүүлэх аймгийн бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. | Бодлого боловсруулан батлуулсан байх | | | Соёл, урлагийг 2017-2020 онд хөгжүүлэх аймгийн бодлого боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны А/314 тоот захирамжаар байгуулан, уг бодлогын төслийг боловсруулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 3.4.2 | Байгалийн задгай театруудын менежментийг сайжруулж, аймаг, бүс, улсын болон олон улсын чанартай урлаг соёлын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | Гадна талбайд угсардаг тайз гэрэлтүүлэгтэй болно. | Угсардаг тайзтай болсон байх | | | Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр гадна талбайд угсардаг тайз, гэрэлтүүлэгтэй болж, аймаг, бүс, улсын болон олон улсын чанартай урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. | 100 |
| 3.4.3 | Монголын соёл, шинжлэх ухаан, шашны нэрт зүтгэлтэн, их номч, мэргэн гавьж Зава хэмээх Шагдарын Дамдины мэлмий гийсний 150 жилийн ой, Хөдөлмөрийн Гавьяаны улаан тугийн одонт, Алдарт уртын дуучин Д.Балдирын мэндэлсний | Монголын соёл, шинжлэх ухаан, шашны нэрт зүтгэлтэн, их номч, мэргэн гавьж Зава хэмээх Шагдарын Дамдины мэлмий гийсний 150 жилийн ой, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, алдарт уртын дуучин Д.Балдирын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ. | Тусгай төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тэмдэглэн өнгөрүүлсэн байх | Ойн арга хэмжээг тусгай төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тэмдэглэн өнгөрүүлэх | 1.5 сая | Монголын соёл, шинжлэх ухаан, шашны нэрт зүтгэлтэн, их номч, мэргэн гавьж Зава хэмээх Шагдарын Дамдины мэлмий гийсний 150 жилийн ой, Хөдөлмөрийн Гавьяаны улаан тугийн одонт, Алдарт уртын дуучин Д.Балдирын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 25 тогтоолоор, аймгийн Засаг даргын 2017 оны А/74 дугаар захирамжаар комисс томилон ажиллуулсан. Уг арга хэмжээг аймгийн баяр наадамтай хамтатган өргөжүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэн, тусгай хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан ажилласан. Ойн хүрээнд “Түгээмэл яруу” хүндэтгэлийн тоглолтыг шинээр найруулан тавьж, 1000 гаруй үзэгч түмэнд өргөн барьсан. Энэ үеэр “Алтан дэвтэр” номонд зориулсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ. | | | | | хөшөө босгож, хүндэтгэл үзүүлсэн. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн хошой одонт, Алдарт уртын ду учин Д.Бальдирын мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан түүний бүтээл туурвила ас оруулсан “Гавьяат болоогүй гавьяат” ном хэвлү үлэн, “Алтан тал” хуурцаг гаргаж, олны хүртээл бол голоо. Энэхүү ном, хуурцагийг гаргахад аймг ийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1500000 төгрө г гарган зарцуулсан. | |
| 3.4.4 | Байгалийн задгай театруудын менежментийг сайжруулж, аймаг, бүс, улсын болон олон улсын чанартай урлаг соёлын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | Байгалийн задгай театруудын менежментийг сайжруулж, аймаг, бүс, улсын болон олон улсын чанартай урлаг соёлын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1-2 үйл ажиллагаа зохион байгуулсан байх | | | Байгалийн задгай театруудын менежментийг сайжруулж, аймаг, бүс, улсын болон олон улсын чанартай урлаг соёлын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөлт гарган ажиллаж, “Их газрын чулуу”-ны задгай театрт Гурвансайхан сумын ардын авьяастнууд, ТХДЖТ-ын уран бүтээлчид хамтран уртын дуу, морин хуурын тоглолтыг Америкийн урлаг судлаачдад зориулан 06-р сарын 09-10-нд тоглосноор, уртын дууны хоолойн бичлэг хийлгэж, өөрийн орны урлаг соёлыг амжилттай сурталчиллаа. Мөн Сүм Хөх бүрдэд “Мянган оюутнуудын чуулга” уулзалт арга хэмжээг зохион байгуулан 700 гаруй оюутан сурагчдыг, “Эргэн дурсахуй“ 30 жилийн уулзалт шоу зохион байгуулж, 200 гаруй багш, төгсөгчийг хамруулан урлаг соёлоо түгээн сурталчилж чадлаа. Мөн жуулчдыг өөрийн нутагт татан иргүүлэх зорилгоор соёл урлагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний эвент зураглал, календарчилсан хөтөлбөр гарган БСШУСЯ-ны нэгдсэн төлөвлөлтөд оруулан ажиллалаа. | |
| 3.4.5 | Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 115 жилийн ойг тохиолдуулан “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын наадам хийж, түүний нэрэмжит өсвөрийн уртын дуучдын улсын уралдааныг зохион байгуулна. | Морин хуур, уртын дууны сургагч багш нарыг бэлтгэн, сургалт явуулж, морин хуур, уртын дууны хамтлаг, чуулга байгуулан, дуу хуураа өвлүүлэн хөгжүүлнэ. | Бүх сумдад морин хуур, уртын дууны сургагч багш нар бэлтгэгдсэн байх<br><br>Сум бүрт морин хуур, уртын дууны хамтлаг, чуулга байгуулагдан сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон байх | | | Морин хуур, уртын дууны сургагч багшаар ТТХТ-ын уртын дууны багш МУГЖ Ж.Дүнжмаа, морин хуурын багш МУСТА Б.Эрдэнэбаяр нар ажиллаж, аймгийн хэмжээнд морин хуур, уртын дууны сургалтад 15 сумаас тус бүр 2 буюу нийт 28 хүн хамрагдан морин хуур, уртын дууны сургагч багшаар бэлтгэгдэн “Гэрчилгээ” гардан авлаа. Орон нутгийн сургагч багшаар бэлтгэгдсэн багш нар “Уяхан замбу тивийн наран”, “Энх мэндийн баяр”, “Эр бор харцага” уртын дуug төв халхаар, “Цэвцгэр хурдан шарга” уртын дууг боржигоноор, “Говь нутгийн татлага”, “Магтаал”, “Монгол аялгуу”, “Үүлэн бор” морин хуурын аялгууг тус тус сонгон сурлаа. Энэ оны жилийн эцсийн байдлаар 15 суманд 176 хүний бүрэлдэхүүнтэй 22 морин хуурын хамтлаг, 15 суманд 22 уртын дууны хамтлаг, чуулга шинээр байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжин, аймгийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцож байна. | 100 |
| 3.4.6 | Дуу хуур бидний өв соёл” сумдын соёл урлагийн өдрүүд болон албан байгууллагуудын урлагийн үзлэгийг зохион байгуулж, | Нутгийн алдартан, гавьяатнуудын нэрэмжит уралдаан, наадмыг зохион байгуулж, тэдний уран бүтээлийг залгамж хойч үедээ өвлүүлэн уламжлуулна. | 2-оос доошгүй алдартан, гавьяатны нэрэмжит уралдаан, наадам зохион байгуулсан байх | | | -Ж.Дорждагвын нэрэмжит “Дуу хуурын өлгий нутгийн үр сад” урлагийн наадмыг зохион байгуулж, 711 авьяаслаг хүүхдүүд оролцож, өмнөх оныхоос 54,6 %-иар өссөн байна.<br>- “Дэмбэрэл сан”, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр хамтран Ж.Дэмбэрэл багшийн нэрэмжит “Найрал дуу”-ны уралдааныг зохион явуулж, давхардсан тоогоор 900 хүүхдийг оролцуулсан нь шинэлэг арга хэмжээ боллоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлнэ. | | | | | -Эстрадын дуучин МУГЖ Х.Төмөрбаатарын нэрэмжит “Эстрад дуу” –ны наадамд 32 ардын авъяастан оролцсоноос ЭДЦСургуулийн 12-р ангийн сурагч Э.Банзрагч, Д.Мэндсайхан нар тэргүүлж, 300 гаруй үзэгч үзэж сонирхлоо.<br>-МУГЖ, нэрт алиалагч Д.Батсүхийн нэрэмжит “Өсвөрийн циркчдын улсын уралдаан”-ыг зохион байгуулж, Улаанбаатар, Эрдэнэт, Сэлэнгэ, Дорноговь, Булган, Дорнод зэрэг аймаг, хотын циркийн 20 хамтлагийн 200 шахам циркчид авьяас чадвараа сорин оролцсон. Энэхүү уралдаан нь хөдөө орон нутагт анх удаагаа зохион байгуулагдаж байгаагаараа онцлог боллоо. | |
| 3.4.7 | Аймгийн нийт нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг харьяалах сумдын хамгаалалтад авахуулан, хадгалалт хамгаалалтыг нь сайжруулна. | Аймгийн нийт нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг харьяалах сумдын хамгаалалтад авахуулан, хадгалалт хамгаалалтыг нь сайжруулна. | Аймгийн ИТХ-ын шийдвэр гаргуулсан байх | | | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04-р сарын 25-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор Сумдын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлуулсан. Энэхүү жагсаалтаар нийт 15 сумын 290 дурсгалыг тухайн сумдынх нь хадгалалт хамгаалалтад авхуулсан бөгөөд сумдын Засаг дарга нарт албан тоотоор хүргүүлэн, хяналтад авхуулаад байна. | 100 |
| 3.4.8 | “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг өрнүүлэн, гэрчилгээ олгоно. | “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг үргэлжлүүлэн дүгнэж, гэрчилгээжүүлнэ. | Угийн бичгээ хөтөлсөн өрхийг өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлсэн байх<br><br>Шалгаруулж гэрчилгээ олгосон байх | | | -Угийн бичгээ ирүүлсэн удмынханд болон сумдын Нийгмийн бодлогын ажилтнуудад зориулан “Угийн бичиг хөтлөх нь” зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Угийн бичгээ ирүүлсэн удмынхан 10%-аар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн нийт хүн амын 61,8% нь угийн бичиглэлээ хөтөлсөн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -“Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг зохион байгуулж, 7 сумаас ирсэн 22 удмын бичиглэлтэй танилцан, ажлын хэсгээр хэлэлцүүлэн, санал хурааж, 1 удамд “Гэрчилгээ”, 8 удамд “Дурсамж”, 6 удамд “Талархал” өгөхөөр шийдвэрлэв. | |
| 3.4.9 | “Дуу хуур бидний өв соёл” сумдын соёл урлагийн өдрүүд болон албан байгууллагуудын урлагийн үзлэгийг зохион байгуулж, биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлнэ. | Соёлын биет бус өв болон уг өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэн, бүртгэн баримтжуулах чиглэлээр сургалт зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэнэ. | Шавь сургалт зохион байгуулж, биет бус өвлөгчдийг олноор бэлтгэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлсэн байх | | - | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 6 хүнийг шинээр илрүүлэн бүртгэж, бүртгэл мэдээллийн сан үүсгэсэн. Дундговь аймгаас төрөн гарсан 4 мастер оёдолчин МСҮТ-ийн оёдлын ангийн 20 оюутантай ярилцлага зохион байгуулж өвлүүлэн уламжлуулах ажлын эхлэлийг тавьсан. Хүүхдийн театрт “Ардын язгуур урлагийн дугуйлан”-г тогтмол хичээллүүлэн, 20 хүүхдийг хамруулж, үндэсний хэл, соёл, өв уламжлал, зан заншлаасаа өвлүүлэн суралцуулж байна. Аймгийн Музей, сургууль, цэцэрлэг хамтран уламжлалт тоглоом наадгай, үндэсний хувцасны талаар хүүхдүүдэд хичээл зааж, 5 төрлийн үйл ажиллагаанд 578 хүүхэд, 35 багш ажилчид, эцэг эхийн төлөөллийг хамруулсан. Мөн ЕБС-ийн 6-9 -р ангийн хүүхдүүдийн дунд "Дөрвөн бэрх" тэмцээнийг зохион байгуулж, нийт 48 сурагч 8 багш, номын санч 2, хөгжөөн дэмжигч 50 хүүхэд хамрагдлаа. Ёс заншлын холбогдолтой үйл ажиллагаанд 170 багш, эцэг эх, хүүхэд, хамруулсан. Аймгийн БСУГ, Ахмадын хороотой хамтран “Ахмадын урлагийн III наадам”-ыг 3 бүсээр зохион байгуулж, нийт 300-д ахмад ардын авьяастнуудыг уртын дуу, ардын дуу, ардын язгуур урлаг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ардын хөгжим, ардын бүжиг зэрэг 5 төрлөөр хамруулан, зан заншил, ардын урлаг соёлоо түгээн сурталчиллаа. Урлагийн наадмыг Өлзийт, Говь-Угтаал сумын ахмад авьяастнууд тэргүүллээ. Дундговь аймгийн ахмад болон тэргүүлэх зэрэгтэй багш нарын аймгийн анхдугаар зөвлөгөөний үеэр МУАБ, МУГБагш Д.Төмөрийн үйл амьдрал, бүтээл туурвилууд, ажлын арга туршлагыг харуулсан нүүдлийн үзэсгэлэнг гаргаж, нийт 250 гаруй хүнд үйлчиллээ.<br>БСШУСЯ-ны дэргэдэх Соёлын өвийн төвийн 2 мэргэжилтнийг урьж ирүүлэн, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэн, бүртгэн баримтжуулах чиглэлээр 2 өдрийн сургалт зохион байгуулж, сумдын Соёлын төвийн эрхлэгч нарыг хамруулан, сургагч багшаар бэлтгэлээ. | |
| 3.4.10 | Сум, сургуулийн номын сангуудад “Цахим номын сан” бий болгож, дуудлагын номын сангийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | Сум, сургуулийн номын сангуудад “Цахим номын сан” байгуулж, дуудлагын номын сангийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | Сум, сургуулийн номын сангуудын 20-оос дээш хувьд нь “Цахим номын сан” байгуулсан байх<br><br>Дуудлагын номын сангийн үйлчилгээг нэвтрүүлсэн байх | | | -Аймгийн Төв номын сан нь 15080 нэр төрлийн 37566 ширхэг монгол номыг цахим каталогит бүртгэж, 103.242.45.74 бодит хаяг бүхий электрон каталогийг ашиглалтад оруулж, ирэгсдийн хэрэгцээг хурдан шуурхай хангах, үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан.<br>-Сум, сургуулийн нийт номын санчдын 21 буюу 63,6% нь “Цахим номын сан үүсгэх” сэдэвт сургалтанд хамрагдаж, Өндөршил, Гурвансайхан сумдын номын сан цахим номын санг үүсгэж эхлээд байна.<br>-Аймгийн төв номын сан 7059-3786 утсаар захиалга авч, дуудлагын номын сангаар үйлчилж эхэлсэн нь шинэлэг ажил үйлчилгээ болж, 20 гаруй иргэн үйлчлүүлээд байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4.11 | | Монгол Улсын гавьяат Алдарт уран зохиолч С.Буяннэмэхийн 115 жилийн ойн хүрээнд Дундговь нутгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын наадмыг зохион байгуулна. | Ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байх<br><br>Нутгийн зохиолч, найрагчдын хамрагдалтын тоо өссөн байх | | 1,858,600 ЗД нөөц хөрөнгөөс | Монгол Улсын Гавьяат Алдарт уран зохиолч С.Буяннэмэхийн 115 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны А/391 тоот захирамжаар байгуулан, бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Ойн хүрээнд “Монгол бичгийн их хүн” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн, “Төгөлдөр Буяннэмэх сан” ТББ-тай хамтран нийслэл хотноо зохион байгуулж, аймгаас төлөөлөгчид оролцлоо. Энэ үеэр Монгол улсын соёлын хосгүй үнэт өв болсон С.Буяннэмэхийн бүтээл туурвилыг түгээн сурталчлах зорилгоор “Сономбалжирын Буяннэмэх” цуврал номын 4 дүгээр ботийг хэвлүүлэн, нээлтээ хийсэн бөгөөд аймгаас 1 сая төгрөгийн санхүүжилт гаргасан. Мөн тус ойд зориулсан “Найргийн тэнгэр” яруу найргийн наадмыг 12 сарын 06-нд зохион байгуулахаар удирдамжаа батлуулан, сумдад хүргүүлж, АС цогцолбороор сурталчилаад байна. Энэхүү наадмын арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.858.600 төгрөгийг гарган, дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| ***3.5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1 | Хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна. | Хүүхдийн паркийн цахилгаан тоглоомын тоог нэмэгдүүлнэ. | ✓ 1-2 цахилгаан тоглоом шинээр нэмж суурилуулсан байх | | 3 сая | 3 орчим сая төгрөг зарцуулан Хүүхдийн паркийн тоглоомын нэр төрлийг нэмэгдүүлж автомат машин 2, зөөлөн тоглоом чимхэгч 2ш, чихэр чимхэгч 2, хүч соригч 1 ширхэгийг авч, мөсөн котокын  <br>30:20-ын харьцаатай мөсөн гулгуурын талбайг 42:20-ын харьцаатай болгон томсгосон нь орчин үеийн тоглоомоор тоглоомын нэр төрлөө нэмэгдүүлж хүүхэд, залуучууд гэр бүлээрээ чөлөө цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөл сайжраад байна.<br>  | 100 |
| 3.5.2 | | Хараа хяналтгүй болон хүнд үрчлэгдсэн хүүхдийн мэдээллийг агуулсан судалгаа мэдээллийн сантай болж бүртгэл хяналтыг сайжруулна. | ✓ Судалгаатай болсон байх<br>✓ Тэдэнд тавих анхаарал хяналт сайжирсан байх | | - | - Хараа хяналтгүй хүүхдийн судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажилласан ба судалгааны дүнгээр хараа хяналтгүй хүүхэд бүртгэгдээгүй байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 0-2 настай хүүхдийн судалгааг авч нэгтгээд байна.Үрчлэгдсэн хүүхдийн нарийвчилсан судалгааны дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилгоор ГБХЗХГ-ын 2017 оны 172 тоот албан бичгийг УБҮӨГ-т хүргүүлээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.3 | Хүүхэд залуучуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөөрүүлэх орчин нөхцөлийг сайжруулна. | “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн гадна хашаа, тоглоомын талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Хашаа шинэчлэгдсэн байх<br>✓ Талбайг тохижуулж, тоглоомын нэр төрлийг нэмэгдүүлсэн байх | | | - 100 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Бүрдийн уянга” зуслангийн “Сансар”, “Мандал” бүлгүүдийн дээвэр засварын **зураг, төсвийг** “Барт төсөл” ХХК-аар хийлгэж, төсвийг 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөнд тусгуулахаар саналыг хүргүүлээд байна.<br>- 202 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Бүрдийн уянга” зуслангийн гадна хашааны **зураг төсвийг** “Чансаа холдинг” ХХК-аар хийлгэж, төсвийг 2018 оны улсын төсөвт суулгах саналыг хүргүүлээд байна.<br>- Чех улсын элчин сайдын яаманд хүүхдийн зуслангийн тоглоомын талбайн 52 сая төгрөгийн төслийг хүргүүллээ.<br>- <br>Зуслангийн 4 бүлгийн байрны гадна 8 сандал шинээр хийж, өндөр хүчдэлийн шонгийн засварыг хамт олноо дайчлан засаж сайжрууллаа. | 40 |
| 3.5.4 | Говийн бүсийн хүчирхийллийн эсрэг төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гэр бүл, хүүхдийн хамгаалагдах орчныг сайжруулна | Говийн бүсийн аймгуудын хүчирхийллийн эсрэг төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, гэр бүл, хүүхдийн хамгаалагдах орчныг сайжруулна. | Төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байх<br><br>Байрны орчин нөхцөл сайжирсан байх | | | Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн харьяа “Говийн бүсийн мэдээлэл үйлчилгээний төв” буюу түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд хамгаалах байр тохижуулан, засвар үйлчилгээ хийж, 2017 оны хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай 2.559.600 төгрөгийн төсөл бичин, АЗД-ын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 16 дугаар хурлаар хэлэлцэж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс, хүний нөөцийг цалинжуулах 1.000.000 төгрөгийг ГБХЗХГ-аас тус тус бүрэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэсэн болно.<br>-АЗДТГ, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ, ГБХЗХГ-ын хооронд хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор гурвалсан гэрээг 2017 оны 12 дугаар сарын 03-ны өдөр байгууллаа. Шаардлагатай засвар үйлчилгээг хийж байна. | |
| 3.5.5 | “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ | “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих”, “Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих” аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | ✓ Хөтөлбөрүүд батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан байх | | - | Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төсөлтэй уялдуулан, “Гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан, ГБХЗХГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 160 тоот албан бичгээр дэд хөтөлбөрийн төсөлд иргэдийн саналыг авахаар сумдын Засаг дарга нараас саналыг авч Засаг даргын зөвлөлийн хурлаар хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэн Үндэсний хөтөлбөр батлагдсаны дараагаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. | 70 |
| 3.5.6 | | Залуучуудын хөгжлийн төвийг ГБХЗХГ-ын дэргэд байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан,залуучуудын сайн дурын бүлгүүдийн санаачлагыг дэмжинэ. | Бүлгэм байгуулагдаж үйл ажиллагаа тогтмолжсон байх<br><br>Мэдээлэл, сурталчилгаа хийсэн байх | | - | - ГБХЗХГ-т залуучуудын хөгжлийн албыг байгуулан, залуучуудын асуудал хариуцсан 2 мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаа явуулах 2 өрөө байрны асуудлыг шийдвэрлэх шатандаа явж байна.<br>ГБХЗХГ-ын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 157 тоот албан бичгээр сумдын Засаг даргын дэргэд сумын залуучуудын бүлгэмийг байгуулж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль сурталчлах 14 хоногийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна. Нэгдсэн тайланг 2017 оны 12 дугаар сарын 03-ны дотор нэгтгэнэ.<br>*2017 оны 11 дүгээр сарын байдлаар Залуучуудын хөгжлийг дэмжих тухай* | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *хуулийн танилцуулгыг байгууллага аж ахуй нэгжүүдэд болон Сайнцагаан, Өндөршил, Гурвансайхан, Хулд, Луус сумдын нийт 2000 гаруй иргэнд хүргээд байна.* | |
| 3.5.7 | Өсвөр үе, залуучуудын хөгжил, оролцооны хөтөлбөр боловсруулж, залуучуудын чуулганы 2 жил тутамд зохион байгуулна. | “Залуусын дуу хоолой” чуулган, хэлэлцүүлэг зохион байгуулж, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа 18-35 насны залуучуудын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ. | Нэгдсэн мэдээллийн сантай болсон байх<br>Чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх | | | Тусгай бэлтгэсэн анкетын дагуу 15 сумдын 15379 залуучуудын судалгааг нэгтгээд байна.<br>“Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төсөлтэй уялдуулан, орон нутгийн “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан, төсөлд иргэдийн саналыг авахаар 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ГБХЗХГ-ын даргын 160 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нарт хүргүүлээд байна. 2017 оны 12 дугаар сард батлагдана.<br>Залуучуудын чуулганыг 2017 оны 12 дугаар сард зохион байгуулахаар чуулганы удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. | 40 |
| 3.5.8 | | Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна. | ✓ Сургалтын удирдамж, төлөвлөгөө гаргаж 2 үе шаттай сургалт зохион байгуулагдсан байх | | | Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Цагдаагийн газар, Дэлхийн Зөн Дундговь ОНХХ-тэй хамтран, 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр “Жаргалтай гэр бүл” 2 сарын аян зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан. Тус аяны хүрээнд Сайнцагаан сумын зорилтот 40 гэр бүлийг сонгон авч, гэр бүлийн 8 модуль сургалтыг зохион байгуулж, гэр бүлийн эрүүл мэнд, хөгжил оролцоо, нийгмийн хамгааллын олон талт асуудлыг шийдвэрлэсэн чухал аян болсон.<br>“Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” аяны хүрээнд Дэлхийн зөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дундговь ОНХХ-тэй хамтран “Өөдрөг амьдрахуйн нууц” гэр бүлийн сургалтыг өрх толгойлсон 25 эмэгтэй, 16 эрэгтэй, 5 залуу гэр бүлүүд, албан байгууллага, аж ахуй нэгжийн 324 эмэгтэйчүүд, 107 эрэгтэйчүүд нийт 482 хүнд зохион байгуулав.<br>“Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Аймгийн Засаг даргын 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/526 тоот захирамжаар гэр бүлийн уламжлалт ёс заншлыг залуу хойч үеийнхэнд уламжлуулан өвлүүлэх зорилгоор “Тэнгэрлэг гэр бүл”-ийг шалгаруулах журмыг үндэслэн жил бүр аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-үүдийг шалгаруулдаг уламжлалын дагуу сумдаас гэр бүлүүдийн тодорхойлолтуудыг авч нэгтгэн, Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн 5 номинациар гэр бүлүүдийг шалгаруулж, 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдөр буюу “Олон улсын гэр бүлийн өдөр”-өөр алдар гавьяаг нь алдаршуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.<br>Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран Адаацаг, Сайнцагаан, Луус, Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдын зорилтод 120 өрхийг хамруулсан “Өнөөдрийн оролцоо маргаашийн боломж” 6 сарын аяныг эхлүүлээд байна. | |
| ***3.6.Хөдөлмөр эрхлэлт нийгмийн хамгааллын чиглэлээр*** | | | | | | | |
| 3.6.1 | 3.1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу 300 | Нийтийн төлөөх бүтээн байгуулалтын ажилд ажилгүй зорилтот бүлгийн иргэдийг хамруулна. | ✓ 400 иргэнийг түр ажлын байраар хангасан байх | | 80.0 | 2017 оны ХЭДСангийн төсвийн хүрээнд **166 иргэнийг** түр ажлын байранд зуучилж **56,5 сая төгрөгийг** зарцуулслаа. Үүнд:<br>“Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд” - **100** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртэл мэргэжилтэй ажилчин бэлтгэн, 2000-аас доошгүй иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилна. | | | | | **иргэнийг** хамруулж, **28 сая төгрөг,** "Хүнсний ногоо тариалах арга хэмжээнд" - **38 иргэнийг** хамруулж, **18 сая төгрөг,** "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ"-д - **32 иргэнийг** хамруулж, **10.5 сая** төгрөг, Мөн 2017 онд Орон нутгийн хөгжлийн сангийн /ОНХС/ хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд **207 иргэнийг** түр ажлын байранд зуучлаад байна. Үүнд:<br>Дэрэн сум - 19,<br>Адаацаг сум - 25,<br>Дэлгэрцогт сумын – 14,<br>Дэлгэрхангай сумын ЭМТөвийн барилгын ажилд- 10,<br>Эрдэнэдалай сум - 10,<br>Өлзийт сум Байгаль орчны сангийн ажилд - 24,<br>Гурвансайхан сум - 22,<br>Говь-Угтаал сум – 5<br>Луус сум - 9,<br>Сайнцагаан суманд - 69 иргэн<br>Аймгийн хэмжээд нийт **373** иргэнийг түр ажлын байраар хангаж **67,7 сая** төгрөг зарцуулсан. | |
| 3.6.2 | 3.1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу 300 хүртэл мэргэжилтэй ажилчин бэлтгэн, 2000-аас доошгүй иргэдийг сул чөлөөтэй ажлын байранд | Зорилтот бүлгийн иргэдэд сургалтын байгууллагатай хамтран мэргэжил олгох түр сургалтыг зохион байгуулна. | ✓ Ажилгүйдэлд бүртгэлтэй зорилтот бүлгийн 30 иргэнд мэргэжил эзэмшүүлж, гэрчилгээ олгосон байх | | | 2017 оны ХЭДС-ийн төсөв хөрөнгөөр Ажилгүйдэлд бүртгэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй зорилтот бүлгийн **98 иргэнд** мэргэжил эзэмшүүлж, мэргэжлийн үнэмлэх болон чадамжийн гэрчилгээг олгож ажиллалаа.<br>1. Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран үсчин мэргэжил олгох давтан сургалтад – **24 иргэн, 3,072,000 төгрөг,**<br>2. ХҮГ, ХХААГ, МСҮТ, ГБАЗТөвтэй хамтран малчин мэргэжил олгох давтан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зуучилна. | | | | | сургалтад **49 иргэн, 1,832,600 төгрөг**<br>3. ЭН БИ ЭС ЭЙ СИ” сургалтын төвтэй хамтран худалдагч, касс, нярвын сургалтад- 25 иргэнд 2,800,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Ажилгүйдэлд бүртгэлтэй ажилгүй **35 иргэн мэргэжил эзэмшиж, гэрчилгээ** авсан. Ажилгүйдэлд бүртгэлтэй ажилгүйдэлд өртөж болзошгүй **63 иргэн мэргэжлийн ур** чадвараа ахиулж, ажлын байраа хадгалан үлдсэн. Үүнд нийт **7,7 сая төгрөг** зарцуулж мэргэжлийн ур чадвар эзэмшүүлж, гэрчилгээ олгосон. | |
| 3.6.3 | 3.1.15 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй аймаг болох хөдөлгөөн өрнүүлэн, тэдэнд тохирсон төрөл бүрийн заслын үйлчилгээг шинээр үзүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааг тогтмолжуулж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна. | ✓ Комиссын хурлыг тогтмолжуулж, үйл ажиллагаа нь сайжирсан байх<br>✓ Холбогдох хуулийн хэрэгжилт 90-ээс дээш хувьд хүрсэн байх<br>✓ Салбар дундын уялдаа холбоо сайжирсан байх | | 200.0 | Аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/92 тоот захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг байгуулан, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн 5 дах өдрийн 14 цагт тогтмол хуралдаж энэ хугацаанд нийт 185 хүүхэд хамрагдсан Үүнд:<br>1. Шинээр хөгжлийн бэрхшээлтэйгээр - 29 хүүхэд тогтоогдож,<br>2. Сунгалт - 142,<br>3. Онош тодруулах шаардлагатай байсан - 14 хүүхдийг буцаасан байна.<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 178 хүүхэд байнгын асаргааны нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдаж 219,056,000 төгрөгийг олгосон байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн салбар комисс нь хамтын ажиллагаагаа өргөжүүлэн JIKA олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор төслийн ажилтан Shoko UEHARA-тай хамтарч аймгийн 2, 3 дугаар сургууль, 6 дугаар цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэгийн болон салбар коиссын хурлын үйл ажиллагаатай танилцаж судалгаа хийлээ.<br>Аймгийн ГБХЗХГ, Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сонсох” өдөрлөгийг Сайнцагаан сумын хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 50 хүүхэд, асран хамгаалагчдын дунд зохион байгуулж Аймгийн засаг даргатай “Нүүр тулсан” уулзалт ярилцлагыг зохион байгууллаа.<br>Аймгийн НБХ, “Энэрэлийн түүчээ” ТББ-тай хамтран “Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөгөө” сэдэвт сургалтыг зохион байгуулж 22 асран хамгаалагч эцэг эхчүүд, багш нар сертификат гардуулсан. Мөн Герман улсын мэргэжилтнүүд ирж үзлэг оношилгоо хийн, заавар зөвлөгөө өгч ажилласан нь эцэг, эх үйлчлүүлэгчдэд нэлээдгүй үр дүнтэй ажил болсон.<br>Мөн сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нар, Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран гэртээ байдаг эцэг, эхчүүдэд арьсан эдлэлээр бэлэг дурсгалын зүйл хийх талаар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багш нарыг чадавхижуулах сургалтыг тус тус | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулж, сургалтад нийт 50 багш хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадварт суралцсан. | |
| 3.6.4 | 3.6.18Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт тавих ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу үе шаттай зохион байгуулна. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны үйл ажиллагааг сайжруулна. | ✓ Төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг тооцсон байх<br>✓ Салбар хорооны гишүүд болон аймаг, сумд, байгууллагын удирдах ажилтнуудыг сургалтад хамруулсан байх | | | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хорооны 2017 оны үйл ажиллагааны 12 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан салбар хорооны даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сэдвээр байгууллагуудын хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтнүүд, сумдын Тамгын газрын дарга, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт хийлээ. Мөн Дорноговь аймагт болсон Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургалтанд салбар хорооны гишүүдийн төлөөлөл оролцлоо. | 100 |
| Үнэлгээ | | | | | | | 91,7 |

**ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД**

Хүнс хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, *үр дүн* | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /сая/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***4.1. Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр*** | | | | | | | |
| 4.1.1 | АЗДҮАХ-ийн - 4.1.6 | Усны хайгуул хийх, инженерийн хийцтэй болон гар худаг гаргах, сэргээн засварлах, булаг шандын эхийг хаших зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ. | Уст цэгийн тооны өсөлт<br>Булаг шандны тооны өсөлт | | | 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 гүн өрмийн худгийг тендерт шалгарсан "Эхний-Эхэн" ХХК Сайнцагаан, Дэлгэрцогт сумдад гаргаж хүлээлгэн өгөөд байна. Худгийн өрөмдлөгийн машин гэрээгээр эзэмшигч Элбэгсанчир ХХК нь Сайнцагаан Адаацаг сумдад гэрээний дагуу 8 худаг гаргаж байна. Дэрэн суманд 1 өрх -8,5 сая төгрөгөөр 1, Адаацаг суманд 13 өрх 48,0 сая төг 13, Дэлгэрцогт суманд 2 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малчин 2 цооног-14,0 сая төг, Сайнцагаан сум ОНХС-ын 12,0 сая төгрөгөөр 8 энгийн уурхай худгийг, Өлзийт сум 14 энгийн уурхай худгийг 21,0 сая төгрөгөөр, Гурвансайхан сум 4 энгийн уурхайн худгийг 8,0 сая төгрөгөөр тус тус сэргээн засварласан буюу шинээр гаргасан. Үүний үр дүнд 70,0 мян га бэлчээрийг усжуулж, 100 гаруй малчин өрхийн 80,0 гаруй мянган мал усаар хангагдаж урьд оноос 26 худаг шинээр нэмэгдсэн. Бэлчээр усжуулалтын хүрээнд 2017 онд нийт 276,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.<br>Сайхан-Овоо сумын Ширээгийн булаг, Хулд сумын Бүлээн булаг, Дэлгэрцогт сумын Тал булгийг тус бүр хашиж хамгаалсан. | |
| 4.1.2 | | Тухайн оны өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэх, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. | Нөөц бүдүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ | | 40.0 ОНХСан , УТХ- 80,0 ОНХ-23,5 нийт -143,5 | Аймгийн хэмжээнд Улсын нөөц-2, сумдад-17 агуулахтай байна. Сумдууд ОНХС-ийн хөрөнгөөр өвс, тэжээлийн агуулах шинээр барьж, сэргээн засварласан ба өвс тэжээлийн агуулахгүй сум байхгүй. Сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд 610,8 тн өвс 238,7 тн тэжээлийн нөөцтэй буюу дунджаар сумын нөөц 77,4 %, аймгийн аюулгүй нөөцөд 238 тн өвс, 40 тн тэжээлийн нөөцтэй буюу дунджаар 102,6 % -иар бүрдүүлж , аймгийн хэмжээний аюулгүй нөөцийн бүрдүүлэлт одоогийн байдлаар 90 хувьтай хангасан. | 100 |
| 4.1.3 | | Тэжээлийн нэг ба олон наст ургамал тариалах ажлыг өргөтгөх, бага оврын цех байгуулж, тэжээлийн хангамж нэмэгдүүлж ажиллана | Хадлан тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдсэн байх | | Аймаг, сумын ОНХС, бусад эх үүсвэр | Хулд суманд иргэн Т.Төмөрчулуун 0,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж байна. Аймгийн хэмжээнд нийт 30,5 га талбайд малын тэжээлийн ургамлын тариалан урьд оноос тариалсан талбай 0,5 га-р нэмэгдсэн хэдий ч усны нөхцөл байдлаас шалтгаалан 30 га талбайд | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ургац алдаж 2017 онд нийт 3.5 тн ургац хураан авсан. | |
| 4.1.4 | | Малын ангилалт баталгаажуулалтад мал сүргийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна. | Шилмэл,1-р ангийн малаар цөм сүргийн малыг сэлбэх | | 18.0 Улсын төсөв, орон нутгийн төсөв | Аймгийн 5 төрлийн малын ашиг шимийн үзүүлэлтийг тогтоох ажлыг орон нутагт зохион байгуулах, мал үржлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2017 оны 03 сарын 10-ны өдрийн А/66 тоот захирамжаар томилон сумдад ажилласан. Эрдэнэдалай, Адаацаг, Цагаандэлгэр, Сайнцагаан, Говь-Угтаал сумын хонин сүрэг, Хулд Өлзийт сумын тэмээн сүрэг, Өндөршил, Эрдэнэдалай, Хулд, Адаацаг сумын адуун сүрэг, Өлзийт, Хулд, Гурвансайхан суманд Говь гурван сайхны эрлийз, бусад суманд улаан ямааг голлон анхаарч үржүүлж байна. Аймгийн мал сүрэг нь махны чиглэлийн ашиг шимтэй болох нь үзүүлэлтүүдээр тогтоогдсон. Ажлын хэсгийн дүгнэлтээр Хулд сумын Олдохын талын тэмээ, Өндөршил сумын Адуу, Сайнцагаан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Адаацаг сумдын хонь бусад үүлдрийн малаас ялгагдах шинж төрхтэй байсан тул Сорилын биологийн хүрээлэнтэй хамтран генетик шинжилгээ хийлгэхэд "Олдохын хүрэн бор" тэмээ, "Далай цагаан" хонь, "Шил" адуу нь бусад үүлдэр омгийн малаас ялгарах шинж төрхтэй, нарийн шинжлэх ухааны үндэслэлтэй судлахад омог, үүлдэрээр баталгаажих боломжтой нь тогтоогдсон. | 100 |
| 4.1.5 | АЗДҮАХ-ийн - 4.1.7 | Гойд ашиг шимт малтай болон цөм торгон сүрэгтэй малчин өрхийг тодруулж | Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байх | | Улсын төсөв, орон нутгийн төсөв | Бог малын хээлтүүлэгчийг Хулд сумын "Хулд таван эрдэнэ" ХХК-д мэргэжлийн мал үржлийн байгууллагын хяналтан дор зохион байгуулснаар бог малын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн сан бүрдүүлэн өсвөр хээлтүүлэгч бэлтгэн нийлүүлэх эрхийг олгож хэвшүүлнэ. | | | | хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялгах ажил аймгийн хэмжээнд хийгдсэн.<br>Говь-Угтаал сум ОНХСангийн хөрөнгөөр Төв аймгийн Сүмбэр сумаас “Баяд” үүлдрийн 53 хуц, Сайнцагаан, Адаацаг сумдаас өсвөр 90 хуцыг авч малчдад гэрээгээр маллуулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар МЭҮГазартай байгуулсан гэрээний дагуу нийт 10500 хонинд үзлэг ангилалт явуулсан. Мэдээллийн санг хариуцсан мэргэжилтэн бүрдүүлж ажилласан. Тусгай программ байхгүй.<br>Аймгийн Засаг даргын 2017 А/198 дугаар захирамжаар Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан, Говь-Угтаал сумдын 1120 хээлтүүлэгч, 9380 толгой хээлтэгч малыг хувьсийн ангилалтанд хамруулсан. Ялган суурилсан хээлтүүлэгч малыг ангилалтанд хамруулж, сумдын мэргэжилтнүүдэд заавар зөвлөмж өгсөн.<br><br> | |
| 4.1.6 | АЗДҮАХ-ийн - 4.1.9 | Гадны аймаг сумдаас шилмэл хээлтэгч, хээлтүүлэгчийг худалдан авч нутгийн хонин сүргийн чанарыг сайжруулна. | Барга, баяд, үүлдрийн хуцыг худалдан авчирч нутгийн хонин сүргийн тоо толгой нэмэгдсэн байх | | Аймаг сум ОНХС | Говь-Угтаал сум ОНХСангийн хөрөнгөөр Төв аймгийн Сүмбэр сумаас “Баяд” үүлдрийн 53 хуц, Сайнцагаан, Адаацаг сумдаас өсвөр 90 хуцыг авч малчдад гэрээгээр маллуулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар МЭҮГазартай байгуулсан гэрээний дагуу нийт 10500 хонинд үзлэг ангилалт явуулсан. Аймгийн засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 09 өдрийн А/198 дугаар захирамжаар Эрдэнэдалай, Адаацаг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сайнцагаан, Говь-Угтаал сумдын 1120 хээлтүүлэгч, 9380 толгой хээлтэгч малд хувьсийн ангилалтанд хамруулсан. | |
| 4.1.7 | АЗДҮАХ-ийн - 4.1.12 | Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 1 саяас доошгүй мал сүргийг хамруулна. | 1 саяас доошгүй мал халдварт, паразиттах өвчний урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах | | Орон нутгийн төсөв | Малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 1-р сард 10 сумын 1016,8 мянга, 5-р сард 5 сумын 412,2 мянган хонь, 8-р сард 562,0 мянган хургыг 2 удаагийн вакцинжуулалтад нийт 1991,1 мянган хонийг хамруулан дархлаажуулсан. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 11 сумын 2225 өрхийн 63,3 мянган бод,1111,6 бог мал нийт 1174,9 мянган малд хийж хамгаалалтын бүс бий болгон малын өвчлөлийг зогсоосон. Малын гоц халдварт шүлхий, хонины цэцэг өвчин гарч голомт бий болсон ч өмнөх онтой харьцуулахад халдварт өвчний гаралт буурсан дүнтэй байна.<br>Малын гоц халдварт 2,3 сая, халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 700 мянга, угаалганд 720,0 мянган мал хамруулж нийт үйлчилгээнд хамруулсан мал өмнөх оноос 2,0 саяар нэмэгдлээ. | 100 |
| 4.1.8 | АЗДҮАХ-ийн - 4.1.13 | Мал эмнэлгийн тогтолцоог бэхжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний лабораторийг итгэмжлүүлэх, үйлчилгээ оношлогооны чанарыг сайжруулна. | Мал эмнэлгийн лабораторийг итгэмжлүүлэх, үйлчилгээ оношлогооны чанар сайжруулах | | Улсын болон орон нутгийн төсөв | Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээ, мал эмнэлгийн үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангах үүднээс нэг малын эмчид ногдох малын тоог 50000 толгой малаар тогтоон аймгийн ИТХ-ын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлуулан мөрдөн ажиллаж байна. МЭАЦЛ-ын магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулахаар Стандарт хэмжилзүйн газарт итгэмжлүүлэх хүсэлт өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн. Итгэмжлэлийн үзлэг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалт 12-р сард хийгдэнэ. МЭАЦЛабораторийн үйлчилгээ оношлогоог сайжруулахаар сүүний лактоскайн багажийг авч сүүний тослог, нягт, хольц, хуурай бодис, ураг зэргийг шинжлэх боломжтой байна. | |
| 4.1.9 | АЗДҮАХ-ийн - 4.1.12 | Бруцеллёз өвчинтэй тэмцэх аймгийн стратеги төлөвлөгөө боловсруулж оношлогоо, шинжилгээ, масс вакцинжуулалтын үр дүнг сайжруулах | Вакцинжуулалтанд 600,0 мянган мал, шинжилгээнд 15,0 мянган мал хамруулах | | | Бруцеллёзтэй тэмцэх аймгийн стратеги төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Бруцеллезын вакцинжуулалтыг малын гоц халдварт өвчин гарснаас шалтгаалан аймгийн Засаг даргын захирамж гарган 10 сард хийж 678,7 мянган төл , бруцеллёзын тандалт шинжилгээнд 10,4 мянган мал тус хамрууллаа. Тандалт шинжилгээгээр өвчтэй мал илрээгүй, тарилгын үйлчилгээий хөлсөнд 120,0 гаруй сая төгрөгийг олгуулахаар материалыг бүрдүүлж Мал эмнэлэг үржлийн газарт хүргүүлсэн. | 100 |
| 4.1.10 | АЗДҮАХ-ийн - 4.1.14 | Дэрэн суманд байгуулагдсан тэжээлийн ургамал тариалах ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг өргөжүүлж, аймгийн тэжээлийн үрийн хэрэгцээг бүрэн хангана. | Тэжээлийн ургамлын тариалалт өмнөх оноос нэмэгдсэн байх | | | Хулд суманд иргэн Т.Төмөрчулуун 0,5 га талбайд тэжээлийн ургамал тариалж байна. Аймгийн хэмжээнд нийт 30,5 га талбайд малын тэжээлийн ургамлын тариалсан хэдий ч урьд оноос тариалсан талбай 0,5 га-р нэмэгдсэн хэдий ч усны нөхцөл байдлаас шалтгаалан 30 га талбайд ургац алдаж 2017 онд нийт 3.5 тн ургац хураан авсан. | 40 |
| 4.1.11 | АЗДҮАХ-ийн - 4.1.16 | Өвлийн нарлаг хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагааг тогтмолжуулан хүн амын хүнсний нарийн ногооны хэрэгцээг хангах бодлогыг үе | Аймгийн иргэдийг нарийн ногоогоор хангаж эхэлсэн байх | | - | Өвлийн нарлаг хүлэмжинд ”Өсөх мал”, “Хүрээнэ-Ус” хоршоонууд нь 1200 м.кв талбайд тариалалт хийсэн. Тус хоршоод нь 8-10 нэр төрлийн хүнсний нарийн ногоо тариалж 3,2 тн хүнсний нарийн ногоо хураан авч урьд онтой харьцуулахад 46,8–иар өссөн.. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаттай авч хэрэгжүүлнэ. | | | | Аймгийн хэмжээнд хүлэмжийн талбайн тариалалт өмнөх оноос 1 га-аар, ургацын хэмжээ 8тн-оор нэмэгдсэн байна. Аймгийн ХХҮГ-ын дарга, ХХААГ-ын дарга нарын баталсан "Хамтран ажиллах санамж бичигт тусгагдсан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төслийн "Хүнсний ногоо тариалах" ажлын хүрээнд Сайхан-Овоо, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэрэн сумдын хүлэмжийн аж ахуй эрхлэгч бүлэг хоршоодоос ирүүлсэн 5 бүлгийн 38 иргэдэд 5ш буюу 380 м.кв хүлэмж, үр, бордоо, тоног төхөөрөмжийг нийлүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. ХХААХҮЯамнаас "Атрын-III" аяны хүрээнд хүлэмжийн аж ахуйн хангамжийг сайжруулах зорилгоор нийлүүлэгдэж байгаа хүлэмжээс 20 иргэн ААНэгж авахаар захиалгыг хүлээн авч хүргүүлснээр 15 ширхэг хүлэмж шийдвэрлүүллээ. Үүнээс 4х5 хэмжээтэй 5 ширхэг хүлэмжийг 5 иргэн 30 хувийн урьдчилгаа төлбөрөө төлж авсан ба 6х20 хэмжээтэй 10 ширхэг хүлэмж захиалсан иргэд аваагүй хүлээгдэж байна. 4х5 хэмжээтэй нь 942000 төгрөг бол 6х20 хэмжээтэй хүлэмж нь 3.300.000 төгрөгийн өртөгтэйгээс урьдчилгаа 30 хувийн төлбөрийг төлж үлдснийг 4 жилийн хугацаанд төлж барагдуулах нөхцөлтэй. | |
| 4.1.12 | АЗДҮАХ-ийн - 4.1.15 | Сайхан-Овоо суманд усалгаатай газар тариалангийн /төмс хүнсний ногоо, чацаргана/ аж ахуй байгуулахыг | Төмс хүнсний ногооны тариалалтын талбайн тоо хэмжээ<br>Хураан авсан ургацын тоо хэмжээ | | ОНХСан, Сум хөгжүүлэх сан | Онги голыг түшиглэн 2017 онд нийт 7 га-д тариалалт хийснээс төмс 5,3 га-д тариалж 26,5 тн-ыг, хүнсний ногоо 1,7 га-д тариалж 8,4 тн ургацыг тус тус хураан авсан байна. Энэ нь урьд онтой харьцуулахад тариалсан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжинэ. | | | | талбай 0,6 га-гаар, хураан авсан ургац 1,1 хувиар тус тус өссөн байна. 51,5 га-д Чацаргана тариалж нийт 3 тн жимс хурааж авсан, Чацаргана тариалсан талбай 2017 онд 2 га-гаар нэмэгдсэн байна. | |
| ***4.2. Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны чиглэлээр*** | | | | | | | |
| 4.2.1 | АЗДҮАХ-ийн - 4.2.7 | Хүнс үйлдвэрлэгчдэд “Эрүүл ахуйн зохистой дадал” болон “Үйлдвэрлэлийн зохистой дадлууд”-ын талаар сургалт зохион байгуулж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | ✓ Үйлдвэрийн байр болон технологи ажиллагааны мэдлэг сайжирсан байх<br>✓ Ажиллагсадын эрүүл ахуйн талаар мэдлэг чадвар дээшилсэн байх | | | Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цагаан сар-2017”, “Дундговь Түншлэл 2017” үзэсгэлэн худалдааг үйлдвэрлэгчдийн ажил үйлс, арга туршлага, бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулж бизнес эрхлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцууллаа. Тус худалдаанд 198 иргэн, аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгч оролцсоноос хүнсний бүтээгдэхүүн 70 хувийг эзэлж байсан ба үүнээс 70,9 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалт хийжээ. ХХААХҮЯамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрүүл монгол хүнс - 2017” үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумын өрхийн үйлдвэрлэгч Цэцэгмаа, Буян-Орших, Өөдбаяр, Одончимэг нар нь нийт 600 орчим даршилж савалсан хөмүүл, Дэрэн сумын малчин Д.Маам ааруул ээзгий, цагаан тос зэрэг нийт 260 кг бүтээгдэхүүнээр оролцож нийт 6,9 сая төгрөгний борлуулалт хийж бусад аймгийн үйлдвэрлэгчдээс харилцан туршлага судалсан.<br>2017 онд хүн амд эрүүл аюулгүй хүнсээр үйлчлэх, үйлчилгээний чанар стандартыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох хууль дүрмийн талаарх сургалт, зөвлөгөөг нийт 7 удаа зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж давхардсан тоогоор 400 орчим иргэнийг хамруулж гарын авлага материалаар хангаж мэдлэг мэдээллийг олгосон.<br>10 дугаар сарын 16-наас хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах стандарт, хууль тогтоомжийг хангуулах хэрэгжүүлэх зорилгоор “Чанартай үйлчилгээ- эрүүл хүнс” аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд нийт 18 хоол үйлдвэрлэлийн газарт мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн баг ажиллаж тухайн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ хоолны нэр төрөл чанарыг сайжруулах нэрийн хоолыг бий болгох өдөрлөгийг зохион байгуулж зөвлөгөө өгч ажиллалаа. | |
| 4.2.2 | АЗДҮАХ-ийн - 4.2.8 | “Дундговь түншлэл 2017” болон гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүс, улсын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлнэ. | ✓ Оролцогчдын тоо өссөн байх<br>✓ Борлуулалтын орлого өмнөх оноос өссөн байх<br>✓ Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн байх | | 3.5 ОНТөсөв, хандив тусламж | Аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэн, малчин өрх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, экспортийг дэмжих инноваци болон өртөг шингэсэн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж урамшуулах, худалдан борлуулах орчин бүрдүүлэх зорилгоор “Дундговь түншлэл-2017” үзэсгэлэн худалдааг 2017 оны 9 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд аймгийн төвд зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 14 сумын 138 үйлдвэрлэгч оролцож 16 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр 53,4 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос оролцогчийн тоо 21, бүтээгдэхүүний нэр төрөл 4, борлуулалтын орлого 3,9 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ХХААХҮЯамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ Эрүүл монгол хүнс - 2017” үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумын өрхийн үйлдвэрлэгч Цэцэгмаа, Буян-Орших, Өөдбаяр, Одончимэг нар нь нийт 600 орчим даршилж савалсан хөмүүл, Дэрэн сумын малчин Д.Маам ааруул ээзгий, цагаан тос зэрэг нийт 260 кг бүтээгдэхүүнээр оролцож нийт 6,9 сая төгрөгний борлуулалт хийж бусад аймгийн үйлдвэрлэгчдээс харилцан туршлага судалсан. | |
| 4.2.3 | | Аймгийн аварга тогооч, худалдагч шалгаруулах ур чадварын уралдааныг зохион байгуулж үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | ✓ Тухайн салбарын ажиллагсдын мэдлэг мэргэжил дээшилсэн байх<br>✓ Оролцогчдын тоо өссөн байх | | 1.0 Хандив тусламж | Жил бүр уламжлал болгон зохиогддог “Амтлаг хоол” ур чадварын уралдааныг арав дахь жилдээ Сайнцагаан сумын Засаг Даргын Тамгын Газар, Монголын тогоочдын холбооны Дундговь аймаг дах салбар зөвлөл, Стандарт Хэмжил Зүйн Хэлтэс, Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгууллаа. Тэмцээнд 34 тогооч 3 төрөлд өрсөлдсөн нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл сум 5, оролцогч 7-оор өсч багийн төрлийн ур чадварын тэмцээн шинээр нэмэгдснээр харилцан биенээсээ суралцах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, үйлчилгээний байгууллагын чанар хүртээмжийг сайжруулахад ур дүнгээ өгсөн ажил болсон.<br>Лууc сумын “Миний найдвар” ХХК-ны зоогийн газар нь хоол үйлдвэрлэлээрээ Үндэсний Бизнес | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөгжлийн Нэгдлээс 2 жилд нэг удаа олгодог "Монгол чанар" цом өргөмжлөл хүртлээ.<br>Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх нь" зөвлөлдөх уулзалтын хүрээнд мэргэжлийн тогооч, зөөгч нарын ур чадвар чадамжийг дээшлүүлэх, үндэсний брэнд хоол, үйлчилгээ шалгаруулах, харилцан туршлага солилцох зорилго бүхий говийн бүсийн тогооч нарын дунд зохион байгуулагдсан ур чадвар, спорт урлаг соёлын нэгдсэн арга хэмжээнд Аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр оролцлоо. Уг арга хэмжээнд Сайнцагаан, Эрдэнэдалай, Луус, Өндөршил сумдын 18 төлөөлөлийг оролцож 9 алт, 7 хүрэл медалыг хүртсэн амжилтыг үзүүллээ.<br>10 дугаар сарын 16-наас хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах стандарт, хууль тогтоомжийг хангуулах хэрэгжүүлэх зорилгоор "Чанартай үйлчилгээ- эрүүл хүнс" аяныг зохион байгууллаа. | |
| 4.2.4 | | Монголын тогооч нарын холбооны удирдах ажилтаны "Дундговь-2017" улсын зөвлөгөөнийг зохион байгуулна. | ✓ Салбарын ажилтаны мэдлэг, ур чадвар нэмэгдсэн байх<br>✓ Үйлчилгээний чанар хүртээмжид ахиц гарсан байх<br>✓ Салбарын ажилтнуудын мэдлэг чадвар дээшилсэн байх | | | АМТЛАГ ХООЛ-2017" тогоочдын ур чадварын уралдааныг Аймгийн ЗДТГ-аас Монголын тогоочдын холбооны Дундговь аймаг дахь салбар, ХХААГ, Сайнцагаан сумын ЗДТГ, МСҮТ зэрэг байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулаа. Ур чадварын уралдаанд Сайнцагаан, Эрдэнэдалай, Луус, Говь-Угтаал, Дэлгэрцогт сумдын Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, Хувийн хэвшлийн нийт 34 тогооч мэдлэг чадвараа сорин өрсөлдөж. 3 үе шаттай шалгаруулалтыг явууллаа. Шилдгийн шилдэг тогоочоор Мандал | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн тогооч Д.Алтансүх, Ресторан зоогийн газрын төрөлд тэргүүн байрыг Бүрд Зоогийн газрын тогооч Л.Одгэрэл, дэд байрыг Энхжин зоогийн газрын тогооч Б.Уранчимэг, гутгаар байрыг Өндөр-Ээж цайны газрын тогооч Нарангарав, Сургууль, Цэцэрлэг эмнэлгийн тогооч нарын төрөлд тэргүүн байрыг МСҮТ тогооч Ч.Оюумаа, Дэд байрыг Луус сумын сургуулийн тогооч Н.Ганцэцэг, гутгаар байрыг 2-р цэцэрлэгийн тогооч Т.Цолмонбаяр, багийн төрөлд Эрдэнэсүх ахлагчтай "Соёмбо" баг тэргүүн байр, Эрдэндалай сумын Б.Саранхүү ахлагчтай "Далай" баг дэд байр, Сайнцагаан сумын 2-р сургуулийн Долгорсүрэн ахлагчтай "Ирээдүй" баг гутгаар байранд тус тус шалгарлаа. | |
| 4.2.5 | | ОНХСан, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлыг иргэд, орон нутгийн ТББ-уудтай хамтран явуулна. | ✓ Зээлийн ашиглалт сайжирсан байх<br>✓ ЖДҮ-ийн тоо нэмэгдсэн байх<br>✓ Ажлын байрын тоо нэмэгдсэн байх | | | Сангуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийг ТББ-тай хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэй Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан удирдамжийн дагуу 15 суманд ажиллаж, ОНХС, СХС-ийн үйл ажиллагаа, хэрэгжилт, зарцуулалтын байдал, ЖДҮДС, ХЭДС-гаас зээл авсан иргэд, ААН-үүдийн үйл ажиллагаатай танилцаж, хууль журмын хүрээнд ОНХС-ийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, ХЭДС, СХС-гийн зээлийн зориулалт, эргэн төлөлтөд байнгын хяналт тавих, хугацаа хэтэрсэн зээлийг бууруулах, барагдуулах, бодит ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалахад анхаарч ажиллахыг сумдын Засаг дарга, мэргэжилтэн нарт анхааруулж, холбогдох зөвлөмжийг өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эцсийн ХШҮ-гээр дүгнэнэ. | |
| 4.2.6 | АЗДҮАХ-ийн - 4.2.8 | БНХАУ-ын Эрээн хотод болон аймгийн төвд Дундговьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн борлуулах цэгтэй болгох, үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах асуудлыг судалж дэмжинэ. | ✓ Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн байх<br>✓ Аймагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн борлуулах худалдааны цэгтэй болсон байх | - | - | Аймгийн Засаг дарга, ХОХБТХ-ийн дарга нарын бүрэлдэхүүнтэй албаны хүмүүс 5 дугаар сард БНХАУ-ын "Эрээн" хотод ажлын айлчлал хийх үеэрээ Дундговьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах цэгийг байгуулах тухай саналыг тавьсан. Саналыг Эрээний тал нааштайгаар хүлээн авч тухайн цэгт борлуулалт хийх үйлдвэрлэгчийг эхний 3 сар түрээсийн зардлаас чөлөөлж ажиллуулах боломжтойг илэрхийлсний дагуу манай талаас албан бичиг боловсруулан хүргүүлэхээр ажиллаж байна.<br>2017 оны 01 сарын 15-ны өдөр "Дундговьд үйлдвэрлэв" дэлгүүр нээгдлээ. Тус дэлгүүрт эхлээд 63 үйлдвэрлэгчийн 160 шахам бүтээгдэхүүн тавьсан байна. Энд Дундговийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйлс ч олноор тавьсан нь гадаад, дотоодын аялагчид, аймгаасаа гадагш ажил төрөл, хурал зөвлөгөөнд явах хүмүүст ч эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн юм. Мөн "Монголд үйлдвэрлэв" сэтгүүлд Дундговийн 1 иргэн, 2 ААнэгжийн бүтээгдэхүүний сурталчилгааг хийгээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.7 | | Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаа, мэргэжлийн чиглэлээр хоршин нэгдэх, үйлчилгээний нэгдсэн хэлбэрийн зохион байгуулалтанд орох үүсгэл санаачлагыг дэмжинэ. | ✓ Иргэдийн хөдөлмөр, аж ахуй эрхлэлтийг дэмжих<br>✓ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах<br>✓ Ажлын байрны тоог нэмэгдүүлэх | | - | Энэ оны 4 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод 13 сумын нийт 45 бизнес эрхлэгчид оролцсон аялалыг Дэлхийн зөн ОУБ, Дундговь аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхим Сайнцагаан сумын ЗДТГазартай хамтран зохион байгууллаа. Нийт 12 үйлдвэртэй танилцуулж туршлага судлуулсан.<br>Төв аймагт болсон Ноос, нэхмэл сүлжмэлийн салбарын нэмүү өртгийн сүлжээ бий болгох сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сургалт зөвлөгөөнд тухайн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг хамрууллаа. Мөн Аймгийн Засаг даргын А/172 дугаар Захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор орон нутгийн оёдлын үйлдвэрлэл эрхлэгч 8 иргэнийг сургалтад хамруулж улмаар бараа материалыг зээлийн гэрээгээр олгож 200 ширхэг сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэн 60 гаруй хувийг борлуулаад байна. Адаацаг сумын ахуйн үйлчилгээний төвийг тус сумын харьяат Монгол Улсын "Ахуйн үйлчилгээний гавьяат ажилтан" С.Дорждамбын нэрэмжит болгосноор цаашид тус төвийн үйл ажиллагааны урсгал зардлын асуудлыг бүрэн шийдвэрлэхээр болоод байна. | 100 |
| Үнэлгээ | | | | | | | 90,4 |

**ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД**

Байгалийн нөөцийг зохистой ашиглаж, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэ шатанд гаргаж, аялал жуулчлал, уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, *үр дүн* | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /сая/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***5.1. Байгаль орчны чиглэлээр*** | | | | | | | |
| 5.1.1 | АЗДҮАХ-ийн - 5.1.1 | Өлзийт сумын Дэл хөнжлийн уул, орчмын газрыг улсын, Сайнцагаан сумын Тэвшийн уулын орчмын газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд тус тус авахуулж тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ. | ✓ Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ нэмэгдсэн байх | - | - | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 4-р хурлаар Сайнцагаан сумын “Тэвшийн говь”, “Суман хайрхан, Тогоогийн рашаан” нийт 49686.4 га талбайг аймгийн тусгай хамгаалалтанд авах тухай 2017 оны 04 сарын 25-ны өдрийн 19 тоот тогтоол батлагдлаа. Аймгийн ТХГНутгийн тоо 16 болж, аймгийн ТХГНутгийн хэмжээ 2,2 хувиар нэмэгдсэн байна.<br>Дэл хөнжлийн уул, орчмын газрыг улсын тусгай хамгаалалтанд авахад шаардагдах материалыг бүрдүүлж БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газарт хүргүүлсний дагуу БОАЖЯамнаас Дэл хөнжлийн уул, Цагаан суварга орчмын газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах төлөвлөлтөд оруулаад байна. | 100 |
| 5.1.2 | АЗДҮАХ-ийн - 5.1.2 | Ногоон хэрэм хөтөлбөр, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд аймаг, сумдын төвд шинээр цэцэрлэгт хүрээлэн байгуулах, өргөтгөх, засмал замын дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээр мод тариулна. | ✓ 20,0 га-д 12000-аас доошгүй мод тарьж ургуулах Цагаандэлгэр, Өлзийт сумдын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, 80-аас дээш хувийн ургалттай хүлээж авах | | | Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын хооронд 2017 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээ, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 114 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн Гурвансайхан суманд 2 га, Дэрэн суманд 2 га, Сайхан-Овоо суманд 4 га, Сайнцагаан суманд 2 га, нийт 10 га талбайд ойн зурвасын ажил байгуулахаар Сум дундын ойн анги гэрээгээр гүйцэтгэж байна. . Мөн “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10 га талбайд ойн зурвас байгуулах “Ой судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Ойн зурвас” байгуулах ажлын гүйцэтгэгчийг Орон нутгийн өмчийн газраар зохих хууль журмын дагуу сонгон шалгаруулалт хийж ААН шалгараагүй тул Сум дундын ойн ангитай шууд гэрээ байгуулах 113 тоот зөвлөмж гарч 6 сумын нутаг дэвсгэрт ойн зурвас байгуулсан. Цэцэрлэгт хүрээлэн байгуулах сумдад үүрэг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэл, заавар зөвлөмжөөр хангаж ажилласан. Ургалтын мэдээ гараагүй байна. Энэ ажлын хүрээнд сум дундын ойн анги 8 төрлийн 12000 ширхэг мод сөөгийг дээрх байгууллага, аж ахуйн нэгжид нийлүүлж мод тарих технологи, заавар зөвлөмжийг өгч ургамал ургалтын хугацаан дахь усалгаа арчилгааг сайн хийхийг зөвлөлөө. | |
| 5.1.3 | АЗДҮАХ-ийн - 5.2.1 | Төв суурин газрын ногоон байгууламжинд нийлүүлэх тарьц суулгацыг бэлтгэж, мод үржүүлгийн талбайн үйл ажиллагааг өргөжүүлэн үрсэлгээний хангамжийг нэмэгдүүлнэ. | ✓ Тарьц суулгацын тоо нэмэгдсэн байх<br>✓ Ногоон байгууламжинд нийлүүлсэн суулгацын тоо | | | Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайгаас төв суурин газрын ногоон байгууламжинд нийлүүлэх боломжтой стандартын шаардлага хангахуйц 12000 ширхэг хайлаас, 400 ширхэг улиас, 1200 ширхэг бүйлс, 300 ширхэг шар хуайс зэргийг гарган бэлтгэж, нийлүүлээд байна. Цаашид улиас, улаан сухай, бургас зэргийн суулгац хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 9000 ширхэг суулгац гарах боломжтой бөгөөд суулгац гаргах хүчин чадал 10 хувиар өснө. | 100 |
| 5.1.4 | АЗДҮАХ-ийн - 5.1.5 | Усны тоо бүртгэлд түшиглэн усны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | Төлөвлөгөө батлах, хэрэгжүүлж эхлэх | | | Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулалтын шатандаа хийгдэж байна. Төлөвлөгөөг сав газрын хэмжээнд хийж байгаа учраас цаг хугацаа шаардаж байна. Манайхаас шалтгаалахгүйгээр удааширч байна. Нийтдээ сав газарт 8 аймгийн 59 сум, 1 дүүрэг хамрагддаг. Зөвлөл, нутгийн иргэдийн хэлэлцүүлэг хийхээс гадна салбарын эрдэмтдийн баг судалгаа, боловсруулалт дээр ажиллаж байна. УГГХДТ-ын сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг Усны мэдээллийн “Өнө мөнх-Ундрага” ТББ, ”Ус хөгжлийн түлхүүр-гидрогеологичдын холбоо” хамтран гүйцэтгэж байна. СГЗөвлөлийн I, II, III, IV хуралдааныг зохион байгуулсан. Хуралдаанаар СГЗ-нд хамаарагдах орон нутагт тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар УННМ-ийн төлөвлөгөөнд тусгуулахаар өөрсдийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | саналыг бичиг хэлбэрээр УННМ багт өгч ярилцав.<br>Дээрх төлөвлөгөөнд 8 аймгийн 59 сум, нийслэлийн 1 дүүргийг хамардаг. | |
| 5.1.5 | АЗДҮАХ-ийн - 5.1.6 | Ан амьтны тооллогыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ховор ан амьтны амьдрах орчныг тэтгэж, агнуур зохион байгуулалтыг зохион байгуулна | ✓ Толлого хийгдсэн байх, Ан агнуурын санал хүргүүлэх, агнуурын ажилд хяналт тавих | | | 2017 оны 04 сарын 05-ны өдрийн 05 тоот гэрээг Эко-Үйлчилгээ ТББ-тай байгуулж аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх, менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг 04-р сараас 10-р сарын хугацаанд гүйцэтгээд байна. Дээрх ажлын хүрээнд ятуу, чоно, үнэг, цагаан зээр, хар сүүлт, тарвага, янгир ямаа, аргал хонины тархац нутгийн судалгаа, тоо толгой, сүргийн бүтцийг тодорхойлж, цаашид ашиглах болон хамгаалах менежментийг боловсруулан хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Уг тайлан, төлөвлөгөөг ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн дэмжүүлж, БОАЖЯаманд хүргүүлээд байна. | 100 |
| ***5.2. Аялал жуулчлалын чиглэлээр*** | | | | | | | |
| 5.2.1 | АЗДҮАХ-ийн - 5.2.4 | Жуулчны баазууд, зочид буудлын ажилтнуудыг сургалтад хамруулах, туршлага судлуулах, үзэсгэлэн яармагт оролцуулна. | Сургалт, бусад арга хэмжээнд хамрагдагсдын тоо өссөн байх | | - | "ITM-2017" Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн музей болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 10 аж ахуйн нэгжүүд хамтран аймаг орон нутгаа сурталчлан, аялал жуулчлалын компаниудтай хамтран ажиллалаа. Жуулчны баазууд дунджаар 47 аялал жуулчлалын компанитай гэрээ байгууллаа.<br>Үзэсгэлэнгийн үеэр нийт 11000 гаруй брошур танилцуулга, газрын зураг тараасан.<br>ИГЧБЦГХЗахиргаатай хамтран Их газрын чулууны БЦГ-т аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Төв боржигон Тур" ХХК-ны удирдлага болон үйлчилгээ эрхлэгчдэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц,Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426:2016 стандарт, Зочдыг угтах, үдэх үйлчилгээний талаар сургалтыг зохион байгууллаа.<br>Аймгийн төвийн зоогийн газар, зочид буудал, үйлчилгээний газруудын ажилчдад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Сайнцагаан сумын ЗДТГ, МСҮТ, Говийн бүсийн арга зүйн төв, "Өүлэн эхийн ачлал" ХХК-тай "Зөөгч, бармен, зочид буудлын үйлчилгээний ажилтны мэргэжил олгох сургалт"-ыг 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай зохион байгуулагдаж 20 гаруй хүн хамрагдав. 2017 онд нийт 13474 жуулчин зочилж, урд жилээс 32 хувиар нэмэгдсэн. | |
| 5.2.2 | АЗДҮАХ-ийн - 5.2.2 | Сүм хөх бүрдийн цогцолбор, Их газрын чулууны задгай театр, Сайхан-Овоо сумын задгай театрыг түшиглэн аялал жуулчлалын тусгай арга хэмжээнүүд зохион байгуулна. | Адуу, айраг, тэмээний баяр, соёл, урлагийн болон зан заншлын бусад арга хэмжээ зохион байгуулсан байх | - | Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр | “Зава Дамдины мэндэлсний 150 жилийн ой”, 07 сарын 26-30 өдрүүдэд зохион байгуулагдлаа. ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр эвент арга хэмжээний танилцуулгыг иргэдэд мэдээлсэн. Мөн МАЖХолбооноос жил бүр гаргадаг цаглабарт оруулж сурталчилсан болно.<br>“Монгол айрагны баяр-2017” эвент арга хэмжээг 09 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн ч малын гоц халдварт өвчний улмаас аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/279 тоот захирамжаар аймгийн хэмжээнд аливаа найр наадам, олон нийтийн арга хэмжээг хориглосон тул зохион байгуулагдаагүй болно. | 70 |
| ***5.3. Ашигт малтмал, уул уурхайн чиглэлээр*** | | | | | | | |
| 5.3.1 | | Уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ | Засгийн газрын 2016 оны 179 дүгээр | - | | Аймгийн “ашигт малтмал, уул уурхайн салбарын Зөвлөлдөх уулзалт-2017” зөвлөгөөнийг 05 сарын 05-ны өдөр зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орон нутагт төлсөн татвар, төлбөр, торгууль, хандивыг ил тод мэдээлж ажиллана. | тушаалаар баталсан гэрээ”-ний загвараар бүх сумд гэрээ байгуулсан байх, Олборлолт, орлогын хэмжээ нэмэгдсэн байх | | | байгууллаа. Зөвлөгөөнд нийт 40 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Уг зөвлөгөөн дээр аж ахуйн нэгжүүдтэй байгуулах хамтран ажиллах гэрээний төслийг танилцуулж, хэлэлцүүлж, 05 сарын 22-26-нд, мөн 07 сарын 19-23-ны өдрүүдэд Аймгийн Засаг дарга, ХОХБТХ-ийн дарга, мэргэжилтнүүд Улаанбаатар хотод уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Энэ онд аймгийн хэмжээнд нийт 18 аж ахуйн нэгж 1,4 тэрбум төгрөгийн татвар, төлбөр улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 23 аж ахуйн нэгжээс 200 сая төгрөгийн хандив орон нутагт оруулаад байна. Дээрх мэдээллүүдийг ОҮИТБС-ийн цахим сайдат оруулж, уг сайтад аудит хийх KPMG ХХК-нид холбогдох мэдээллүүдийг өгч ажиллалаа. | |
| 5.3.2 | АЗДҮАХ-ийн - 5.3.2 | Уул уурхай, бичил уурхайн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулахад хяналт тавьж ажиллана | Хяналт шалгалтыг удирдамжийн дагуу хийх, зөрчлийг арилгуулсан байх, зөрчил буурч, эрсдлийн үнэлгээ өссөн байх | - | | МХГазар болон холбогдох газартай хамтран хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлж байна. Мэргэжлийн хяналтын газраас 2017 оны төлөвлөгөөт шалгалт болон Зөвлөн туслах үйлчилгээг үйл ажиллагаа явуулж байгаа 7 аж ахуйн нэгжид хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна. Бичиг баримтыг орд газар дээр байлгаагүй Говьшоо ХХК-ны үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож Зөрчлийн тухай хуулиар 10 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авч ажилласан. | 100 |
| 5.3.3 | АЗДҮАХ-ийн - 5.3.2 | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгаас санал өгөх, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтын тусгай | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх | - | | Он гарсаар ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар АМХГ-аас мэдэгдэл ирээгүй болно. | Үнэлэх болом жгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвшөөрлийг олгох ажлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж ажиллана. | | | | | |
| 5.3.4 | АЗДҮАХ-ийн – 5.3.4 | Уул уурхайн бүтээгдэхүүнийг сайжруулсан болон хатуу хучилттай замаар нэгдсэн маршрутын дагуу тээвэрлэх бодлого баримталж, замын маршрутыг тогтоож мөрдүүлнэ. | Замын маршрут тогтоож мөрдөгдсөн байх | - | | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдын 2017 оны 09 тоот тогтоолоор Ашигт малтмал тээвэрлэх маршрутыг тогтоож, батлагдсан замыг ААнэгжид танилцуулж, байнгын хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, цагдаа, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид үүрэг болгож, тогтоолыг мөрдүүлж ажиллахыг Авто тээврийн төв, Цагдаагийн газар, МХГазар, БОАЖГазарт тус тус даалгаад байна. Тогтоол батлагдсанаас хойш 15 сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид мэдээлэл өгч ажилласан. Мөн 2017 оны 05 сарын 05-нд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНэгжийн зөвлөлдөх уулзалтанд мэдээлэл хийж, маршрутыг танилцуулан, хамтран ажиллах гэрээний төсөлд оруулав. | 100 |
| Үнэлгээ | | | | | | | 91 |

**ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлаж, хүн ардын ая тухтай ажиллах, амьдрах нөхцлийг сайжруулахад чиглүүлнэ.

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин, *үр дүн* | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /сая/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1.1 | АЗДҮАХ-ийн – 6.1.1 | Аймгийн төвд 35 Мвт хүчин чадалтай дулааны станцын дулаан дамжуулах төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | ✓ 4 км дулааны шугамын ажлыг гүйцээж хийсэн байх<br>✓ Дулаан дамжуулах төвийн барилга баригдаж эхэлсэн байх | | | Хөрөнгийн асуудал шийдвэрлэхээр судалгаа тайланг Эрчим хүчний яам руу материалыг хүргүүлэн ажилласан. 2017 оны 08 дугаар сарын 24-нд Бүгд Найрамдах Солонгос улсын "Экспорт Импорт" банкны төлөөлөгчид газар дээр нь ирж танилцан, 2014 боловсруулагдсан ТЭЗҮ-г БНСУ-ын төлөөлөл хангалтгүй гэж үзсэн тул | Үнэлэх боломж гүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Экспорт Импорт” банкны хөрөнгөөр техник эдийн засгийн үзүүлэлтийг дахин боловсруулахаар тендерийг зарлаж 2017 оны 11-р сард компанитай 6 сард ТЭЗҮ боловсруулж дуусгах хугацаатайгаар гэрээ байгуулсан. | |
| 6.1.2 | | Дэлгэрхангай сумын эрүүл мэндийн төвд шинээр барилга барьж ашиглалтанд оруулна. | ✓ Шинэ барилга баригдаж, ашиглалтанд оруулсон байх | | 899,4 Улсын төсөв | Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилгын гүйцэтгэгчээр "ОГОСЦ" ХХК 899,443,354 төгрөгөөр шалгарч, гэрээ байгуулсан. Одоогоор 2 дугаар давхрын хучилтын ажил хийгдэж дууссан. Ажлын явц 30%-тай он дамнасан ажил хийгдэж байна. | 40 |
| 6.1.3 | АЗДҮАХ-ийн - 6.2.5 | Сайнцагаан суманд 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн шинэ барилгыг барьж, ашиглалтад оруулна. | ✓ Шинэ барилга баригдаж, ашиглалтад өгсөн байх | | /концесс/ | “Бармон” ХХК концессын гэрээ эзэмшигчээр шалгарсан ба УИХ-ын 34-р тогтоолоор гэрээ түдгэлзүүлээд байгаа. | Үнэлэх боломж гүй |
| 6.1.4 | АЗДҮАХ-ийн - 3.1.8 | Говь-Угтаал, Дэрэн Баянжаргалан, Өлзийт, Хулд сумдын сум дундын эмнэлэгт автомашины парк шинэчлэлт хийж, Дэлгэрцогт, Дэрэн, Луус,Сайхан-Овоо, Адаацаг сумдын эрүүл мэндийн төвийн багийн эмч нарыг мотоциклиор хангана. | ✓ 5 сумын сум дундын эмнэлэгт автомашинаар хангагдсан байх<br>✓ Хөдөөгийн 5-аас доошгүй багийн эмчийг унаажуулсан байх | | | Говь-Угтаал, Дэрэн Баянжаргалан, Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Хулд, Луус сумдын Эрүүл мэндийн төвд ЭМЯ-аас автомашины парк шинэчлэлтийг хийлээ. ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат 5 суманд багийн эмч нарын мотоцикл олгохоор батламж гардуулсан. | 70 |
| 6.1.5 | АЗДҮАХ-ийн - 6.2.4 | Хүүхдийн паркаас Магнай Трейдийн шатахуун түгээх станц хүртлэх автозамын дагуу явган хүний зам, гэрэлтүүлгийн ажил хийнэ. | ✓ Төлөвлөсөн зам дагуу явган хүний зам тавигдсан байх<br>✓ Төлөвлөсөн зам дагуу гудамжны гэрэлтүүлэгтэй болсон байх | | Замын сангийн хөрөнгөөр-142,4 сая ОНХС-аас 176,4 сая | Гадна гэрэлтүүлгийн ажлын зураг төслийг “Аслаан” ХХК-д боловсруулан хүлээлгэн өгсөн бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн 176,411,651 сая төгрөгөөр гэрэлтүүлгийн ажлыг “Эрчим сансар” ХХК-тай гэрээ байгуулсан. 12 сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Ажлын явц | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 70%-тай.<br>Явган хүний замын ажлын хөрөнгийн асуудлыг Замын сангийн хөрөнгөнд тусгуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд саналыг оруулж хөрөнгийг шийдвэрлэж батлуулан тендер зарлаж, “Мандал шигтгээн” ХХК-тай 11-р сарын 8-нд гэрээ байгуулсан. Материалаа татсан. Улирлын байдлаас шалтгаалан он дамжиж хийгдэж байна. | |
| 6.1.6 | АЗДҮАХ-ийн - 6.2.6 | Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын байрны их засварын ажил /Нэг цэгийн үйлчилгээний төв/-ыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх орчин нөхцөл бүрдсэн байх | | | 2017 оны 04-р сарын 25-ны өдрийн аймгийн ИТХ-ын 15-р тогтоолоор хасагдсан. | Үнэлэх боломж гүй |
| 6.1.7 | | Мандалговь хотын хуучин орон сууцнуудын гадна фасадыг шинэчилнэ. | ✓ 9, 13-р байрны гадна фасад шинэчлэгдсэн байх | | 169,3 ОНХС | Сайнцагаан сумын 9-р байрны гадна фасадын засварын ажлыг “Занданшоориса” ХХК 93 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж улсын комисс хүлээж авсан. Сайнцагаан сумын 13-р байрны гадна фасадын засварын ажлыг “Дархан-Үйлс” ХХК 76,3 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулсан. Техникийн комисс ажлыг хүлээн авсан. | 100 |
| 6.1.8 | АЗДҮАХ-ийн - 6.2.14 | Чагдаржавын төв талбай болон Соёл амралтын хүрээлэнгийн гэрэлтүүлэг, тохижилтийн ажлыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Чагдаржавын талбай гэрэлтүүлэгтэй болсон байх<br>✓ Соёл амралтын хүрээлэн тохижуулагдсан байх | | 94,5 сая УТХО ОНХС | Чагдаржавын төв талбайн тохижилтын ажлын зураг төслийг боловсруулахаар “Гэгээ дизайн” ХХК-тай 7,4 сая төгрөгийн шууд гэрээ байгуулан “Тааны амт” ХХК-тай 35,8 сая төгрөгөөр хийж ажлын явц 95%-тай. Техникийн комисс ажиллаж үүрэг даалгавар өгөөд байна.<br>Соёл амралтын хүрээлэнгийн тохижилтын ажлын зураг төслийг боловсруулахаар “Стийл лайн” ХХК-тай 4,2 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан “Хайя Тек” ХХК-тай 58,6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөгөөр хийж хүлээлгэн өгсөн. | |
| 6.1.9 | | Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Цэнгэлдэх хүрээлэнгийн барилга цахилгаан эрчим хүчинд холбогдсон байх | | | Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна цахилгааны ажлыг захиалагчийн хүсэлтээр түр зогсоогоод байна. Дахин төсөв хийж тодотголоор 11 сарын 15-ны 24-р ИТХ-ын тогтоолоор 50 сая төгрөг баталсан. | Үнэлэх боломж гүй |
| 6.1.10 | | Зөөврийн угсардаг тайз, гэрэлтүүлэг, техник хэрэгслээр хангана. | ✓ Урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулах боломж бүрдсэн байх | | 80,0 ОНХС | Багц-1 “Шувуутай хийморь” ХХК-тай 21 сая, Багц-2 Буурал сутай ХХК-тай 59 сая төгрөгөөр гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. | 100 |
| 6.1.11 | | Аймгийн ЗДТГ-ын зочид буудал, прокурорын орон сууцны их засварыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Засвар хийгдэж зочид хүлээн авах тохилог орчин бүрдсэн байх | | 57,6 ОНХС | Аймгийн ЗДТГ-ын зочид буудал, ЗДТГ-ын эзэмшлийн Прокурорын орон сууцны их засварын ажлыг “Дөл БГМ” ХХК ОНХС-ийн 57.6 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж, улсын комисс ажиллаж ашиглалтанд хүлээн авсан. | 100 |
| 6.1.12 | | Зүүн бүсийн сум дундын эрүүл мэндийн төвийн ажилчдын байрны их засварыг хийж гүйцэтгэнэ. | ✓ Ажилчдын байрын их засвар хийгдсэн байх<br>✓ Амьдрах тав тухтай орчин бий болж эмч эмнэлэгийн ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэгдсэн байх | | 55.5 ОНХС | Аймгийн ИТХ-ын 2017.12.04-ний 25 дугаар тогтоолоор 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад Зүүн бүсийн сум дундын эрүүл мэндийн төвийн ажилчдын орон сууц шинээр авахаар хөрөнгө нь батлагдсан. | Үнэлэх боломж гүй |
| 6.1.13 | | Аймгийн төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн хогийг шуух, дахин булах цэгцлэх ажлыг хийж хогийн менежментийн асуудлыг сайжруулна. | ✓ Хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>✓ Шууж эрүүлжүүлсэн талбайн хэмжээний өсөлт гарсан байх | | 50.0 ОНХС | Сайнцагаан сумын ХТҮГазартай 50 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. | 100 |
| 6.1.14 | | Хүн амын ундны усны нөөц, чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр | ✓ Хөтөлбөр батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан байх | | 38,0 ОНХС | Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтанд “Аймгийн төвийн ундны усны гүний худгуудад хяналтын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулан баталж ундны усыг гадны хүчин зүйлийн нөлөөллөөр бохирдохоос сэргийлэх зорилгоор ус хангамжийн эх үүсвэрүүдийг камержуулна. | ✓ 1 усан сан, 2 **насос** станц, 5 гүний худаг камертай болж ундны усны аюулгүй байдал хангагдсан байх | | | камерын систем суурилуулах” ажилд 40 сая төгрөг батлан ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчээр Риймсофт ХХК-тай 38 сая төгрөгийн гэрээ байгуулан ажлыг хүлээн авсан. | |
| 6.1.15 | | Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | ✓ 6-р баг /малчин/ 128 айлын цахилгааны хүчдэл нэмэгдсэн байх | | 38,9 ОНХС | Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, дэд өртөө барих ажилд ОНХС-д 40 сая төгрөг батлан, ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан “Мон – Энержи Корпораци” ХХК-тай 38,9 сая төгрөгийн гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. | 100 |
| 6.1.16 | | Мандалговь хотын залуучуудын гудамж, төв зам дагуух ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | ✓ Аймгийн төвийн зам дагуу хашаа хайс бүхий ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байх | | | Мандалговь хотын залуучуудын гудамж, төв зам дагуу мод тарих ажил аймгийн МХГ-ын замын уулзвараас - УЦУОШГ-ын замын уулзвар хүртэлх газар, Холбооны уулзвараас - Бүрд зочид буудлын урд талын замын уулзвар хүртэлх 1180 метр газарт ногоон байгууламж бий болгохоор гүйцэтгэгчийг шалгаруулах ажил аймгийн Өмчийн газар зохион байгуулсан боловч тендерт оролцохоор аж ахуйн нэгжүүд материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахаар 4 компанид санал хүргүүлсэн боловч үнийн санал ирүүлээгүй. | Үнэлэх боломж гүй |
| 6.1.17 | | Ард иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилтын хүрээнд 5 сумын хэсгийн төлөөлөгч, 10 багийн Засаг дарга нарыг үе | ✓ 5 хэсгийн төлөөлөгч, 10 багийн даргад мотоциклээр хангагдсан байх | | 27,8 ОНХС | Хөрөнгө шийдэгдэж, 5 сумын хэсгийн төлөөлөгчийг унаажуулах ажлыг “Өнө мөнх хайрхан” ХХК-тай 10 сая төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авч, хүлээлгэн өгсөн.<br>10 багийн Засаг дарга нарыг унаажуулах ажлыг “Өнө мөнх хайрхан” ХХК-тай 17,8 сая төгрөгөөр гэрээ байгуулан хүлээн авч, хүлээлгэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаттайгаар унаажуулна. | | | | өгсөн. | |
| 6.1.18 | | Аймгийн аль ч хэсэгт интернетийн хурд сайтай Wi-Fi болон сүлжээний орчин, үйлчилгээг өргөжүүлж мэдээллийг бүрэн авах боломжийг бүрдүүлнэ. | ✓ Интернетийн хурд нэмэгдсэн байх<br>✓ Мэдээллийг бүрэн авах боломж бүрдсэн байх | | Монголын цахилгаан холбоо ХК-ны хөрөнгөөр | Сумдын иргэдийн хүсэлтээр аймгийн Холбооны газраас Монголын цахилгаан холбоо ХК-ны хөрөнгө оруулалтаар 2017 оны 8 дугаар сард Хулд, Дэрэн, Гурвансайхан сумдад 3 утасгүй интернетийн зони шинээр суурилуулж, , Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдад хэрэгцээ шаардлагыг үндэслэн утасгүй интенетийн өргөтгөл хийж тоног төхөөрөмж нэмж суурилуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэн Хулд, Дэрэн, Гурвансайхан сумдын интернетийн хурд 2-4 мегабайтаар, Сайхан-Овоо сумын интернетийн хурд 4-6, мегабайтаар Эрдэнэдалай сумын интернетийн хурд 4-8 мегабайтаар нэмэгдүүлсэн байна. | 70 |
| Үнэлгээ | | | | | | | 87,5 |
| Нийт үнэлгээний дундаж | | | | | | | 91,2 |

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ БАТАЛГААЖУУЛСАН:

ЗДТГ-ын дарга ...........................Ц.ЭРДЭНЭСҮРЭН

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ХШҮДАХэлтсийн мэргэжилтэн..................... Н.Дэлгэрмаа

2018 оны.. сарын........ний өдөр